



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА- 2015

Үр дүнгийн тайлан



УЛААНБААТАР ХОТ
2016 ОН



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу

Засгийн газрын III байр

Цахим хуудас: <http://www.nso.mn>

И-мэйл: international@nso.mn

Факс: 976-11-324518

Утас: 976-51-265543

Тайлбар: Судалгааны тайланд гарч байгаа үнэлэлт, дүгнэлтүүд нь зөвхөн бичсэн хүмүүсийн санал болно.

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2015 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	v
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	vii
1 УДИРТГАЛ	1
1.1 ТАНИЛЦУУЛГА	3
1.1.1 Цаг ашиглалтын судалгааг явуулах хэрэгцээ, шаардлага	3
1.1.2 Судалгааны зорилго.....	3
1.2 Ойлголт, тодорхойлолт	3
1.3 Судалгаанд ашигласан ангилал.....	6
1.4 Сургамж, хүндрэл бэрхшээл.....	6
1.5 Тайлангийн бүтэц, агуулга	6
2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	7
2.1 Судалгааны түүвэрлэлт	9
2.1.1 Түүврийн хүрээ.....	9
2.1.2 Түүврийн загвар	10
2.1.3 Түүвэрлэгдсэн өрх	10
2.2 Судалгааны асуулга.....	10
2.3 Судалгааны сургалт, мэдээлэл цуглуулалт	10
2.3.1 Мэдээлэл цуглуулах судлаач, багийн ахлагч нарын сургалт.....	10
2.3.2 Мэдээлэл цуглуулалт	10
2.3.3 Өдрийн тэмдэглэл	10
2.4 Мэдээлэл боловсруулалт.....	11
3 ӨРХ, ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	12
3.1 Судалгаанд хамрагдсан өрх, хүн ам	13
3.1.1 Өрхийн сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр.....	13
3.1.2 Өрхийн сууцны халаалт, ундны усны эх үүсвэр.....	15
3.1.3 Судалгаанд хамрагдсан өрхийн хөрөнгийн байдал	16
3.1.4 Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн бүтэц, боловсролын түвшин	18
3.1.5 Судалгаанд хамрагдсан хүн амын гэрлэлтийн байдал.....	20
3.2 Судалгаанд хамрагдсан хүн амын эдийн засгийн идэвх.....	21
3.2.1 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлт.....	21
3.2.2 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны ажиллагчдын дундаж цалин, хөлс, орлого	22
3.2.3 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам.....	23

4 ЦАГ АШИГЛАЛТ	25
4.1 Цаг ашиглалтын ерөнхий дүр зураг, төлөв байдал	27
4.1.1 Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг	27
4.1.2 Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг	30
4.1.3 Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг	31
4.2 Насанд хүрэгчдийн цаг ашиглалт	33
4.2.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг	33
4.2.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг	35
4.2.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг	36
4.3 Хөдөлмөрийн насны хүн амын цаг ашиглалт	37
4.3.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан дундаж цаг	37
4.3.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг	39
4.3.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг	40
4.4 Хүүхэд, залуучуудын цаг ашиглалт	41
4.4.1 Хүүхдийн цаг ашиглалт	41
4.4.2 Залуучуудын цаг ашиглалт	46
4.5 Өндөр настны цаг ашиглалт	56
4.5.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан дундаж цаг	56
4.6 Хүн амын цаг ашиглалт дах боловсролын ялгаа	58
4.6.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг	58
4.6.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг	63
4.6.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг	68
5 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	73
5.1 Дүгнэлт	75
5.2 Зөвлөмж	76
6 ХАВСРАЛТ	77

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Цаг ашиглалтын судалгаанд хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт.....	4
Хүснэгт 2.1.	2015 оны цаг ашиглалтын судалгаанд сонгогдсон өрхийн тоо, аймаг, нийслэлээр	9
Хүснэгт 2.2.	2015 оны цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан аймаг, сумдын нэр.....	9
Хүснэгт 3.1.	Судалгаанд хамрагдсан өрх, бүсээр, хувиар.....	13
Хүснэгт 3.2.	Өрх, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, хувиар	14
Хүснэгт 3.3.	Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, хот, хөдөөгөөр, хувиар	14
Хүснэгт 3.4.	Өрхийн халаалтын төрөл, хот, хөдөө, хувиар, судалгаа, тооллогын дүнгээр.....	15
Хүснэгт 3.5.	Өрхийн ундны усны эх үүсвэр, бүсээр, хувиар	16
Хүснэгт 3.6.	Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгийн сонгосон үзүүлэлтээр, хувиар	16
Хүснэгт 3.7.	Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, байршил, бүсээр, хувиар	20
Хүснэгт 3.8.	Хүн амын гэрлэлтийн байдал, хүйсээр, хувиар	20
Хүснэгт 3.9.	Сарын дундаж цалингийн бүтэц, хот, хөдөө, хүйсээр, хувиар	22
Хүснэгт 3.10.	Сарын дундаж цалин, байршлаар, хүйсээр, судалгааны дүнгээр	23
Хүснэгт 3.11.	Судалгаанд хамрагдсан эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаан, хүйс, хот, хөдөөгөөр, хувиар	24
Хүснэгт 4.1.	Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар.....	27
Хүснэгт 4.2.	Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	29
Хүснэгт 4.3.	Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар.....	30
Хүснэгт 4.4.	Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар.....	31
Хүснэгт 4.5.	Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөө, хүйсээр, минутаар.....	33
Хүснэгт 4.6.	Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар.....	34
Хүснэгт 4.7.	Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	38
Хүснэгт 4.8.	Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нийт дүнд эзлэх хувиар, хүйсээр	39
Хүснэгт 4.9.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар, судалгааны дүнгээр	43
Хүснэгт 4.10.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	43
Хүснэгт 4.11.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар, судалгааны дүнгээр	47
Хүснэгт 4.12.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	48
Хүснэгт 4.13.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	49
Хүснэгт 4.14.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар.....	53

Хүснэгт 4.15.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	53
Хүснэгт 4.16.	Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	54
Хүснэгт 4.17.	Ажлын нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	55
Хүснэгт 4.18.	Ажлын нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар	55
Хүснэгт 4.19.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар.....	61
Хүснэгт 4.20.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	61
Хүснэгт 4.21.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	62
Хүснэгт 4.22.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	63
Хүснэгт 4.23.	Ажлын нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	64
Хүснэгт 4.24.	Ажлын нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	65
Хүснэгт 4.25.	Ажлын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	66
Хүснэгт 4.26.	Ажлын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	67
Хүснэгт 4.27.	Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	67
Хүснэгт 4.28.	Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	68
Хүснэгт 4.29.	Амралтын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар.....	69
Хүснэгт 4.30.	Амралтын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	69
Хүснэгт 4.31.	Амралтын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйс, хот хөдөөгөөр, минутаар	70
Хүснэгт 4.32.	Амралтын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар.....	70
Хүснэгт 4.33.	Амралтын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	71
Хүснэгт 4.34.	Амралтын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	72
Хүснэгт 4.35.	Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	72

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 3.1.	Түүвэрлэгдсэн болон судалгаанд хамрагдсан өрх, хүн ам	13
Зураг 3.2.	Судалгаанд хамрагдсан өрх, хүн ам, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр.....	13
Зураг 3.3.	Судалгаанд хамрагдсан хүн ам, дүнд эзлэх хувиар, бүсээр.....	13
Зураг 3.4.	Гэр, байшинд амьдардаг өрх, дүнд эзлэх хувиар	14
Зураг 3.5.	Өрхийн халаалтын төрөл, бүсээр, хувиар	15
Зураг 3.6.	Судалгаанд хамрагдсан өрх, малын тоогоор, хувиар, судалгааны дүнгээр.....	17
Зураг 3.7.	Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгөөр, байршлаар, хувиар	17
Зураг 3.8.	Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгөөр, бүсээр, хувиар	18
Зураг 3.9.	Судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн бүтэц, хувиар.....	18
Зураг 3.10.	Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин, хүйсээр, хувиар.....	19
Зураг 3.11.	Судалгаанд хамрагдсан хүн амын гэрлэлтийн байдал, бүсээр, хувиар.....	21
Зураг 3.12.	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, хувиар.....	21
Зураг 3.13.	Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар.....	22
Зураг 3.14.	Сарын дундаж цалин, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, мянган төгрөгөөр.....	23
Зураг 3.15.	Судалгаанд хамрагдсан эдийн засгийн идэвхгүй хүн ам, голлох шалтгаан, хүйсээр, хувиар	24
Зураг 4.1.	Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр.....	28
Зураг 4.2.	Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр.....	28
Зураг 4.3.	Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр.....	29
Зураг 4.4.	Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр.....	30
Зураг 4.5.	Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хот, хөдөө, хүйсээр.....	31
Зураг 4.6.	Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр	31
Зураг 4.7.	Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр	31
Зураг 4.8.	Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр.....	32
Зураг 4.9.	Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйс, хот, хөдөөгөөр.....	32
Зураг 4.10.	Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр	32
Зураг 4.11.	Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр.....	33
Зураг 4.12.	Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр.....	35
Зураг 4.13.	Насанд хүрэгчдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр.....	35
Зураг 4.14.	Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр.....	36
Зураг 4.15.	Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	36
Зураг 4.16.	Насанд хүрэгчдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр	36
Зураг 4.17.	Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	36

Зураг 4.18.	Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	37
Зураг 4.19.	Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр.....	37
Зураг 4.20.	Хөдөлмөрийн насны хүн амын ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр	40
Зураг 4.21.	Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	40
Зураг 4.22.	Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	40
Зураг 4.23.	Хөдөлмөрийн насны хүн амын амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр	40
Зураг 4.24.	Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	41
Зураг 4.25.	Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр	41
Зураг 4.26.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр	42
Зураг 4.27.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, судалгааны дүнгээр	42
Зураг 4.28.	Ажлын нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	43
Зураг 4.29.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар	44
Зураг 4.30.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр, хүйсээр.....	44
Зураг 4.31.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар.....	44
Зураг 4.32.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	45
Зураг 4.33.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хувиар	45
Зураг 4.34.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар	46
Зураг 4.35.	Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар.....	46
Зураг 4.36.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр.....	47
Зураг 4.37.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр	48
Зураг 4.38.	Долоо хоногийн, ажлын, амралтын нэг өдөрт залуучуудын мал аж ахуйн ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр.....	48
Зураг 4.39.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр	49
Зураг 4.40.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар	50
Зураг 4.41.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	50
Зураг 4.42.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар.....	51
Зураг 4.43.	Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хүйсээр.....	51

Зураг 4.44.	Долоо хоногийн нэг өдөрт сургууль дээрх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хот, хөдөөгөөр	52
Зураг 4.45.	Долоо хоногийн нэг өдөрт сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хот, хөдөөгөөр	52
Зураг 4.46.	Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэхэд болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр	54
Зураг 4.47.	Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	54
Зураг 4.48.	Ажлын нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	55
Зураг 4.49.	Амралтын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр	55
Зураг 4.50.	Амралтын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр, хүйсээр	56
Зураг 4.51.	Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	56
Зураг 4.52.	Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар	57
Зураг 4.53.	Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, хот, хөдөөгөөр	57
Зураг 4.54.	Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны цалин хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр	57
Зураг 4.55.	Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, хот, хөдөөгөөр	58
Зураг 4.56.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин, хувиар	58
Зураг 4.57.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	59
Зураг 4.58.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	59
Зураг 4.59.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	60
Зураг 4.60.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	60
Зураг 4.61.	Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хувиар	62
Зураг 4.62.	Ажлын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин, хувиар	63
Зураг 4.63.	Ажлын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар	65
Зураг 4.64.	Ажлын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар	66
Зураг 4.65.	Амралтын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, минутаар	71



**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
УДИРТГАЛ**



1.1 ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заасны дагуу Цаг ашиглалтын судалгаа (ЦАС)-г 2015 онд гурав дахь удаагаа явуулаад байна. Энэхүү судалгаанд улсын хэмжээнд нийт 4000 өрхийг хамруулан явуулсан.

1.1.1 Цаг ашиглалтын судалгааг явуулах хэрэгцээ, шаардлага

Монгол Улсад ЦАС-г явуулж байгаа нь 1985 онд Кени Улсын нийслэл Найроби хотноо хуралдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн гуравдугаар бага хурлаас гаргасан “Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх стратеги”-д тусгагдсан хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрийг тооцох зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа ажил юм. Мөн Монгол Улсын “Жендерийн тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөр, хуулийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай мэдээллийг шинэчлэн баяжуулах зайлшгүй шаардлага гарч байна.

Монгол Улсын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн талаарх тоо мэдээлэл нь гол төлөв зах зээлийн үйл ажиллагаанд хүн амын зарцуулж байгаа цагийг тооцож үнэлэх боломжийг олгодог бол ЦАС нь өрхийн түвшинд зах зээлийн бус үйл ажиллагаанд зарцуулж байгаа цагийг тооцож үнэлэхэд ашиглагдах мэдээллийн нэг гол эх үүсвэр юм. Иймээс ЦАС-ны үр дүнгээр гарч байгаа хөлсгүй хөдөлмөрийн талаарх мэдээлэл нь өрхийн гишүүдийн дотор хөлсгүй хөдөлмөр хэр зэрэг тэгш хуваарилагдаж байгаа, эмэгтэйчүүдийн үүрч байгаа ачаалал, нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг ролийг харуулах, хөдөлмөрийн зах зээл дээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх боломж тэгш олдож байгаа эсэхийг судлахад хэрэгтэй байдаг. Түүнчлэн судалгааны үр дүн нь ядуурал, ажилгүйдлийг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд жендерийн тэгш байдлыг хангахад анхаарсан бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийн эх үүсвэр болдог.

ЦАС-ны гол ач холбогдол нь хөлсгүй хөдөлмөрт өрхийн гишүүдийн зарцуулж байгаа цагийг тодорхойлж гаргах, хүн амын цаг зарцуулалтын ерөнхий дүр зургийг гаргах, өрхийн түвшинд бий болж байгаа нэмэгдэл өртгийг тооцох, ҮТС-д шаардлагатай тоо мэдээллийг гаргах түүнчлэн бодлого боловсруулахад хэрэгцээтэй тоо мэдээллээр хангахад оршино.

1.1.2 Судалгааны зорилго

Хүн амын эрхэлж байгаа үйл ажиллагааг тодорхойлон, хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цагийг хүйсээр гаргах, амьдралын хэв маягийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг шинэчлэх, баяжуулахад судалгааны гол зорилго оршино. Түүнчлэн хүн амын эрхэлж буй үйл ажиллагааг тодорхой хугацаанд буюу жил, сараар тодорхойлж, тэдгээрийг ангилан хэмжих зорилго тавьсан бөгөөд судалгааны зорилтыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

1. Хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр, насны 5 бүлгээр гаргах;
2. Хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, түүнд гарч буй өөрчлөлтийг судлах;
3. Албан бус секторын нэмэгдэл өртгийн тооцооны хамралтыг нэмэгдүүлэх,
4. Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2015 онд дуусч байгаатай холбогдуулан түүний хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай статистик мэдээллийг баяжуулах, тооцох.

Цаг ашиглалтын судалгаа нь өрхөд суурилдаг түүвэр судалгаа бөгөөд судалгааны гол хэмжүүр нь өрхийн гишүүдийн эрхэлж буй үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг хугацааны үзүүлэлт юм.

Судалгаагаар хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт хүн амын зарцуулсан цаг, эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, өндөр настан зэрэг хүн амын тодорхой бүлгүүдийн эрхэлж буй үйл ажиллагаа, тэдгээрт зарцуулж буй цагийг тодорхойлж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалтанд шаардлагатай мэдээллийг үндэсний түвшинд болон хот, хөдөөгөөр, хүйсээр гэх зэрэг боломжит бүхий л задаргаагаар тооцож, гаргасан болно.

1.2 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Цаг ашиглалтын судалгаанд болон энэхүү үр дүнгийн тайланд нийгмийн чиглэлийн түүвэр судалгаанд нийтлэг ашигладаг ойлголт, тодорхойлолтыг хэрэглэсэн болно.

Хүснэгт 1.1. Цаг ашиглалтын судалгаанд хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт

№	Ойлголт	Тодорхойлолт
Өрх, хүн ам		
1	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг болон хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
2	Өрхийн тэргүүлэгч	Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-гаас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
3	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ.
Хөгжлийн бэрхшээл		
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэнэ.
Боловсрол		
5	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 он ба түүнээс хойш) төгсөөгүй бол боловсролгүй гэж үзнэ.
6	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 он ба түүнээс хойш) төгссөн хүн
7	Суурь боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл), 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал), 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
8	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10-р ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
9	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль- ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
10	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
11	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ.
Гэрлэлт, гэр бүл		
12	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
13	Батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
14	Батлуулаагүй	Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
15	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.

16	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ.
17	Бэлбэсэн	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хэлнэ.
Хөдөлмөр эрхлэлт		
18	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)	Тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.
19	Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа б сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна.
20	Ажиллагч	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статусд хамрагдаж буй иргэн байна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагч гэж үзнэ.
21	Ажиллах хүчний оролцооны түвшин	Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, хөдөлмөрийн насны хүн амын тооны харьцаагаар илэрхийлэгдэнэ.
22	Ажилгүй иргэн	Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.
23	Ажилгүйдлийн түвшин	Ажилгүй иргэдийн тоо, эдийн засгийн идэвхтэй хүн амын тооны харьцаагаар илэрхийлэгдэнэ.
Сууцны төрөл		
20	Орон сууцны байшин	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
21	Бие даасан тохилог сууц	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.
22	Сууцны тусдаа байшин	Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
23	Нийтийн байр	Иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй сууцыг хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байна. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр орно.
24	Зориулалтын бус бусад байр	Хүн амьдрах зориулалтаар бариагүй албан ажлын, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл болон хөдөө аж, ахуйн гэх мэт зориулалтаар баригдсан боловч хүн амьдарч байгаа барилга, байгууламж, орц, хонгил орно.
25	Гэр	Бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг хамруулна.

1.3 СУДАЛГААНД АШИГЛАСАН АНГИЛАЛ

ЦАС-нд дараах ангиллуудыг ашиглана.

1. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
2. Үндэсний ажил мэргэжлийн ангилал
3. Цаг Ашиглалтын Статистикт зориулсан Үйл Ажиллагааны Ангилал (ЦАСҮАА)

Дээрх ангиллуудаас ЦАСҮАА нь зөвхөн энэ судалгаанд ашиглагддаг ангилал юм. ЦАС-нд зориулан НҮБ-ын Статистикийн Хэлтсээс боловсруулж гаргасан Цаг Ашиглалтын Статистикт зориулсан Үйл Ажиллагааны Олон Улсын туршилтын ангилал (ICATUS¹)-ыг 2011 оны судалгаанд ашигласан. Харин энэ удаагийн судалгаанд 2012 онд шинэчлэгдсэн хувилбарыг мөрдлөг болгон өөрийн орны онцлог нөхцлийг тусган үндэсний ангиллыг боловсруулж батлуулан ашигласан.

ЦАСҮАА нь ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний үйл ажиллагаа, ҮТС-ийн өргөтгөсөн хүрээний үйл ажиллагаа, ҮТС-ийн бус үйл ажиллагаа гэж 3 ангилагдах бөгөөд үндсэн 8 бүлэгтэй байна. Үүнд:

1. ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээний үйл ажиллагаанууд
 - 1.1. ҮТС-ийн хүрээний үйл ажиллагаа
2. ҮТС-ийн өргөтгөсөн хүрээний үйл ажиллагаа
 - 2.1. Өрх гэрийн ажил, нүүдэл
 - 2.2. Өрхийн гишүүдийг цалин, хөлсгүй асрах
 - 2.3. Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж
3. ҮТС-ийн бус үйл ажиллагаа
 - 3.1. Боловсрол, суралтын үйл ажиллагаа
 - 3.2. Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл
 - 3.3. Чөлөөт цаг, спорт
 - 3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Өмнөх судалгаанд 3 оронтой ангиллыг ашигласан бөгөөд энэ удаад өмнөх ангилал дээр шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг тусгаж 4 оронгийн түвшинд үндэсний ангиллыг баяжуулсан.

1.4 СУРГАМЖ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Судалгаанд хамрагдсан өрхүүд идэвхтэй оролцож, сүүлийн долоо хоногт хийсэн үйл ажиллагааныхаа талаар өдрийн тэмдэглэлд

хөтөлсөн бөгөөд цөөн тооны өрхийн гишүүд өдрийн тэмдэглэл хөтлөхөөс татгалзах, хагас дутуу нөхөх зэргээр мэдээлэл цуглуулалтанд хүндрэл учруулж байлаа.

Энэ удаагийн цаг ашиглалтын судалгааны мэдээллийн кодлолыг тухай бүрт нь мэдээлэл цуглуулсан судлаач бус мэдээлэл бүрэн цуглуулагдсаны дараа ҮСХ-ны ажилтнууд хийсэн. Энэ явцад судалгаанд хариулагчийн үйл ажиллагааны задгай бичвэрийг судлаач тодорхой бичээгүй, утга агуулгагүй үг, үсэг байсан зэрэг ямар ажил хийсэн нь мэдэгдэхгүй байсан нь үйл ажиллагааг кодлоход нилээдгүй хүндрэл учруулсан. Мөн эдгээр алдааг тухай бүр нь бус, мэдээлэл нэгтгэгдэж ҮСХ-ны санд ирсэний, судалгааны мэдээлэл цуглуулагдсанаас хойш багагүй хугацааны дараа эргэн тодруулах нь хариулагчаас тодруулга хийхэд хүндрэлтэй байсан. Иймээс цаашид үйл ажиллагааны задгай бичвэр болон түүний кодлолыг анхаарч судалгааны мэдээлэл цуглуулалт хийгдэж байх явцад орон нутагт кодлолт хийгдэх нь цаг хугацаа алдахгүй мэдээллийн бодит байдал хангагдана гэж үзэж байна.

1.5 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

Судалгааны тайлан нь дүгнэлт, зөвлөмж, хавсралтыг оролцуулаад нийт зургаан бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт, судалгааны танилцуулга, зорилго, сургамж, хүндрэл бэрхшээл, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, энэ тайлангийн бүтэц, агуулгыг тусгав.

Хоёрдугаар бүлэгт, судалгааны түүвэрлэлт, асуулга, мэдээлэл цуглуулалт, мэдээлэл боловсруулалт зэрэг судалгааны арга зүй, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг орууллаа.

Гуравдугаар бүлэгт, судалгаанд хамрагдсан өрх, өрхийн үзүүлэлтүүд, хүн амын талаарх мэдээллийг багтаасан болно.

Дөрөвдүгээр бүлэгт, хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зураг болон насанд хүрэгчид, хөдөлмөрийн насны, өндөр настан, хүүхэд, залуучууд гэх зэрэг тодорхой бүлгүүдийн цаг ашиглалтын дүр зургийг гарган харуулав.

Тавдугаар бүлэгт, цаг ашиглалтын судалгааны гол дүгнэлт, зөвлөмжийг оруулав.

Зургаадугаар бүлэгт, судалгааны гол үзүүлэлтүүдийг хавсралт хүснэгт хэлбэрээр орууллаа.

¹ International Classification of Activities for Time-Use Statistics



ХОЁРДУГААР БҮЛЭГ
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



2.1 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

2.1.1 Түүврийн хүрээ

Монгол Улсын нийт өрхийг төлөөлүүлэн түүврийн хэмжээг тогтоосон бөгөөд нийт өрхийн 0.5 хувь болох 4000 өрхийг түүвэрлэсэн юм. Судалгаа нь дөрвөн улирлыг хамарсан тул түүвэрлэгдсэн нийт өрхийн тоог дөрвөн улиралд тэнцүү хуваасан болно.

Хүснэгт 2.1. 2015 оны цаг ашиглалтын судалгаанд сонгогдсон өрхийн тоо, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Судалгаанд сонгогдсон нийт өрхийн тоо	Улиралд сонгогдсон өрхийн тоо
Баруун бүс	640	160
Завхан	320	80
Ховд	320	80
Хангайн бүс	800	200
Баянхонгор	320	80
Өвөрхангай	480	120
Төвийн бүс	800	200
Дорноговь	320	80
Сэлэнгэ	480	120
Зүүн бүс	560	140
Дорнод	240	60
Хэнтий	320	80
Улаанбаатар	1 200	300
Дүн	4 000	1 000

Уг судалгаанд зургаан сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон засан хүмүүжүүлэх газар байгаа) иргэдийг хамруулаагүй болно.

Баруун, Хангай, Төв, Зүүн болон Улаанбаатар хот гэсэн таван бүсийг төлөөлөх нийт 8 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэг судалгаанд хамрагдсан.

Судалгаанд бүсээ төлөөлж буй аймгуудын нэр бүхий сумд, нийслэлийн дүүргүүдээс сонгогдсон өрхүүдээс мэдээлэл цуглуулсан.

Хүснэгт 2.2. 2015 оны цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан аймаг, сумдын нэр

Бүс	Аймаг	Сум/ дүүрэг
Баруун	Завхан	Улиастай, Асгат, Баянхайрхан, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Тосонцэнгэл, Тэлмэн, Тэс, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан
	Ховд	Жаргалант, Булган, Буянт, Дөргөн, Зэрэг, Мөнххайрхан, Мянгад, Үенч, Цэцэг, Чандмана
Хангай	Баянхонгор	Баянхонгор, Баянбулаг, Баянлиг, Баян-Өндөр, Богд, Бууцагаан, Галуут, Жаргалант, Заг, Хүрээмарал, Эрдэнэцогт
	Өвөрхангай	Арвайхээр, Баруунбаян-Улаан, Бат-Өлзий, Баянгол, Богд, Гучин ус, Зүйл, Нарийн тээл, Өлзийт, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хархорин, Хужирт
Төв	Дорноговь	Сайншанд, Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Замын-Үүд, Иххэт, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ
	Сэлэнгэ	Сүхбаатар, Алтанбулаг, Баруунтүрүүн, Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Сайхан, Сант, Хүдэр, Цагааннуур, Шаамар
Зүүн	Дорнод	Хэрлэн, Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Гурванзагал, Матад, Хөлөнбуйр, Чойбалсан
	Хэнтий	Хэрлэн, Батноров, Батширээт, Баян-Овоо, Биндэр, Галшар, Дархан, Жаргалтхаан, Норовлин, Өмнөдэлгэр, Бор-Өндөр
Улаанбаатар		Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх, Багануур

2.1.2 Түүврийн загвар

Судалгаанд шаталсан түүврийн арга буюу хоёр шатат түүврийг ашигласан.

Шат 1: Пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан таван бүсийг төлөөлүүлэн өрхийн тоог пропорционалиар тогтоосон. Энэ аргаар Баруун бүсээс 640 өрх, Хангайн бүсээс 800 өрх, Төвийн бүсээс 800 өрх, Зүүн бүсээс 560 өрх, Улаанбаатар хотоос 1200 өрх сонгов.

Бүс бүрээс нийт өрхийг төлөөлөх өрхийн тоог тогтоосны дараа Улаанбаатар хотын төвийн 8 дүүргийг тус бүр нэг бүлэг, үлдсэн 4 бүсийг төлөөлүүлж тус бүр 2 аймгийг санамсаргүйгээр сонгосон. Түүврийн анхан шатны нэгж нь аймгийн хувьд баг, Улаанбаатар хотын хувьд хорооны хэсэг байсан бөгөөд түүврийн анхан шатны нийт 200 нэгж (ТАШН)-ийг өрх, хүн амын хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан бүлэг тус бүрээс сонгож тогтоов.

Шат 2: Судалгааны түүврийн анхан шатны нэгж буюу сонгогдсон баг, хэсэг тус бүрээс 20 өрхийг системчилсэн магадлалт түүврийн аргаар сонгосон.

2.1.3 Түүвэрлэгдсэн өрх

Судалгаа нь өрхөд суурилсан судалгаа учир мэдээлэл цуглуулах анхдагч нэгж нь өрх юм. Судалгаанд 4000 өрхийн 14173 хүн сонгогдсоноос 3990 өрхийн 13626 хүн хамрагдлаа. Судалгаанд 12 ба түүнээс дээш насны 10091 хүн сонгогдсоноос 6914 нь судалгааны мэдээлэл цуглуулалтанд бүрэн хамрагдаж, өрхийн ганцаарчилсан асуулгад хариулсан болно.

2.2 СУДАЛГААНЫ АСУУЛГА

Судалгааны зорилго, зорилтыг харгалзан өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан судалгааны асуулга, түүнийг нөхөх заавар, ангиллыг боловсруулсан бөгөөд Европын Холбооны Статистикийн байгууллага (Евростат) болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн Хэлтэс (НҮБСХ)-ийн зөвлөмж, арга зүй, бусад улс орны туршлагыг гол лавлагаа болгон ашиглав.

Цаг ашиглалтын судалгаанд хоёр төрлийн асуулгын хуудас ашигласан. Үүнд:

1. Өрхийн асуулга (маягт ЦАС-1): Өрхийн болон ганцаарчилсан асуулгаар өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, өрхийн сууцны байдал, ус болон ариун цэврийн байгууламжийн хангамж, цахилгаан, дулааны эх үүсвэр, хөрөнгө, 12 ба

түүнээс дээш насны өрхийн гишүүдийн боловсрол, гэрлэлтийн байдал, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээлэл цуглуулсан.

2. Өдрийн тэмдэглэл (маягт ЦАС-2): Өдрийн тэмдэглэлээр 12, түүнээс дээш насны хүн амын өдөр тутмын үйл ажиллагаа, тэдгээрт зарцуулж буй цаг хугацааны талаарх мэдээллийг цуглуулсан.

2.3 СУДАЛГААНЫ СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

2.3.1 Мэдээлэл цуглуулах судлаач, багийн ахлагч нарын сургалт

Судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэх, бүрэн, үнэн зөв, чанартай мэдээлэл цуглуулах үүднээс судалгааны ахлагч, мэдээлэл цуглуулах судлаач нарт зориулсан 2 өдрийн онлайн сургалтыг 2015 оны 3 сарын 11-12-ны өдрүүдэд батлагдсан хөтөлбөр, заавар журмын дагуу зохион байгуулж явуулсан. Сургалтанд судалгаанд сонгогдсон аймгийн статистикийн хэлтсийн дарга нар болон аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн АХС болон ӨНЭЗС-ны судлаач нар нийт 70 хүн хамрагдав.

Сургалтаар судалгааны үндсэн зорилго, ач холбогдол, арга зүй болон судалгаанд хэрэглэгдэх ангилал, ойлголт, тодорхойлолтуудыг тайлбарлан, асуулгын хуудас нөхөх, өдрийн тэмдэглэлийг хэрхэн хөтлөх талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгсөн болно.

2.3.2 Мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2015 оны гурав, зургаа, ес, арван хоёрдугаар сарын гурав дахь долоо хоногт зохион байгуулан явууллаа.

Мэдээлэл цуглуулалтанд лавлагаа болгон авсан хугацаа нь "сүүлийн долоо хоног" буюу судалгаа авч байгаа нэг долоо хоногийн өмнөх долоо хоног байсан бөгөөд бүх гарагийг хамруулсан болно. Судалгааны мэдээлэл цуглуулалт 2015 оны 3 дугаар сард эхэлж 2015 оны 12 дугаар сарыг дуустал үргэлжилсэн юм.

2.3.3 Өдрийн тэмдэглэл

Өдрийн тэмдэглэлийг сонгогдсон өрхийн 12, түүнээс дээш насны гишүүд хөтөлж, хоногийн 24 цагт хийсэн үйл ажиллагаа, тэдгээрт зарцуулсан хугацааг 10 минутын зайтайгаар тэмдэглэсэн болно. Судалгаанд хамрагдагчид 2-3 өдрийн турш өдрийн тэмдэглэл хөтөлж байсан бөгөөд судлаач хөдөөгийн өрхөд 2 удаа, хот, суурин газарт 3 удаа

очиж өдрийн тэмдэглэлийн хөтлөлтийг шалгаж, заавар өгч байв.

Өдрийн тэмдэглэлийг хөтлүүлэхдээ 7 хоногийн гарагуудыг дараах байдлаар 3 бүлэгт хуваан бүлэг тус бүрт тэнцүү тооны өрх ногдуулав (1.Ням, Даваа, Мягмар; 2. Лхагва, Пүрэв; 3. Баасан, Бямба). Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хүн амын гуравны хоёр нь 2 хоног, гуравны нэг нь 3 хоног тэмдэглэл хөтөлсөн гэсэн үг юм.

Өдрийн тэмдэглэлийг сонгогдсон өрхийн судалгааны хугацаанд гэртээ байгаа, судалгаанд бүрэн хамрагдах боломжтой 12 ба түүнээс дээш насны гишүүд хөтөлсөн.

2.4 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулалтад компьютер ашиглан ярилцлага хийх (computer assisted personal interview - CAPI) болон цаасан асуулга ашиглан ярилцлага хийх (paper assisted personal interview - PAPI) аргыг хослуулан ашигласан. Тодруулбал,

судлаач таблет ашиглан өрхийн болон хувь хүний асуулгыг авна. Харин өдрийн тэмдэглэлийг цаасан маягтаар тухайн өрхөөс шалгаж, хүлээж авсны дараагаар компьютерт шивж оруулсан.

НҮБСХ-ээс гаргасан “Цаг ашиглалтын статистикт ашиглах үйл ажиллагааны олон улсын туршилтын ангилал”-ын дагуу өдрийн тэмдэглэлд тусгагдсан үйл ажиллагаануудыг кодлов (Хавсралт 2). Үйл ажиллагаа бүрт зарцуулсан дундаж цагийг бүх хүн амаар, хүн амын тодорхой бүлгүүдээр, нас, хүйс, хот, хөдөө, бүс нутгаар гэх зэрэг боломжит бүх задаргаагаар тооцсон болно.




ГУРАВДУГААР БҮЛЭГ
ӨРХ, ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



3.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХ, ХҮН АМ


Цаг ашиглалтын судалгаанд 4000 өрхийн 14173 хүн хамрагдахаас 3990 өрхийн 13626 хүн хамрагдаж, хамралтын түвшин 99.8 хувьтай байна. Судалгаанд хамрагдсан 3990 өрхийн 1213 буюу 30.4 хувь нь нийслэлд, 855 буюу 21.4 хувь нь аймгийн төвд, 969 буюу 24.3 хувь нь сумын төвд, 953 буюу 23.9 хувь нь хөдөөд амьдардаг өрхүүд байна.

Зураг 3.1. Түүвэрлэгдсэн болон судалгаанд хамрагдсан өрх, хүн ам




Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 51.8 хувь нь хотын, 48.2 хувь нь хөдөөгийн өрх байгаа бол хүн амын 50.9 хувь нь хотын, 49.1 хувь нь хөдөөгийнх байна.

Зураг 3.2. Судалгаанд хамрагдсан өрх, хүн ам, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр



Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 28.9 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 3.3. Судалгаанд хамрагдсан хүн ам, дүнд эзлэх хувиар, бүсээр



Судалгаанд хамрагдсан өрхүүдийн тоо Баруун, Хангай, Төвийн бүс нутгуудаар бараг тэнцүү тархсан (16-20 хувь), харин Зүүн бүс нутгийн өрх нийт өрхийн 13.9 хувь байхад түүвэрлэгдсэн нийт өрхийн 30.1 хувь нь Улаанбаатар хотын өрх байна.

Хүснэгт 3.1. Судалгаанд хамрагдсан өрх, бүсээр, хувиар

Үзүүлэлт	Бүсээр					Улсын дүн
	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
Өрх	638	799	797	556	1 200	3 990
Дүнд эзлэх хувь	16.0	20.0	20.0	13.9	30.1	100.0

Судалгаанд хамрагдсан 10 өрхийн 8 нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 2 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. ЦАС-нд хамрагдсан нэг өрх дунджаар 3.4 ам бүлтэй байгаа бол эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 3.7 ам бүлтэй, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 2.5 ам бүлтэй байна.

3.1.1 Өрхийн сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр

Тухайн өрхийн эзэмшиж буй сууцны төрөл болон дэд бүтцийн үндсэн үйлчилгээнд хамрагдсан байдал нь хүн амын амьжиргааны түвшнийг тодорхойлох гол үзүүлэлтийн нэг юм. Өрхийн сууцны нөхцөл, ахуйн үйлчилгээ, дэд бүтэц сайжирснаар өрхийн амьдрал ахуй дээшилж, өрхийн гишүүдийн бүтээмж нэмэгдэнэ.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 47.9 хувь нь Монгол түмний уламжлалт сууц болох гэрт, 51.7 хувь нь байшинд, үлдсэн 0.4 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.


Хүснэгт 3.2. Өрх, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, хувиар

Үзүүлэлт	Сууцны төрлөөр, %							Өрхийн тоо
	Гэр	Зориулалтын бус сууц	Байшин	Үүнээс:				
				Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн зориулалтын байр	
Бүгд	47.9	0.4	51.7	20.4	1.1	28.2	2.0	3 990
Өрхийн тэргүүлэгчийн хүйс								
Эрэгтэй	49.1	0.4	50.5	19.3	1.3	28.1	1.8	3 102
Эмэгтэй	43.5	0.7	55.8	23.9	0.6	28.8	2.5	888
Суурьшил								
Хот	30.8	0.5	68.7	34.4	1.9	30.3	2.1	2 068
Хөдөө	66.3	0.2	33.5	5.3	0.3	26.1	1.8	1 922

Хотын нийт өрхийн 68.7 хувь нь байшинд, 30.8 хувь нь гэрт амьдарч байна. Улсын хэмжээнд нийт өрхийн 20.4 хувь нь орон сууцны тусдаа байшинд амьдарч байгаа бөгөөд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.4 пунктээр өссөн байна. Энэ

өсөлт нь хөдөө орон нутагт илүү мэдрэгдэж байгаа нь өмнөх судалгааны үр дүнгээс 4.6 пунктээр өсч 5.3 хувьд хүрсэн байгаагаас ажиглагдаж байна. Уг өсөлт нь орон сууцаар хангах бодлого, хөтөлбөр тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх талтай юм.

Зураг 3.4. Гэр, байшинд амьдардаг өрх, дүнд эзлэх хувиар, бүсээр



Гэрт амьдардаг өрхийн 33.0 хувь нь Хангайн бүсэд байгаа нь бусад бүсээс хамгийн өндөр түвшинд байна. Харин байшинд амьдардаг өрхийн 43.5 хувь нь Улаанбаатар хотод, 24.7 хувь нь Төвийн бүсэд амьдардаг байна.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 6.8 хувь нь өөрийн эзэмшлийн сууцгүй өрх байна. Хотод энэ үзүүлэлт 7.9 хувь байгаа бол хөдөөд харьцангуй бага буюу 5.5 хувьтай байна.

Хүснэгт 3.3. Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, хот, хөдөөгөөр, хувиар

Эзэмшлийн хэлбэр	Хот	Хөдөө	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	92.1	94.5	93.2
Бусдын сууцанд түрээстэй суудаг	3.1	2.0	2.6
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	4.3	2.8	3.6
Бусад	0.5	0.7	0.6

3.1.2 Өрхийн сууцны халаалт, ундны усны эх үүсвэр

Сууцны халаалт, ундны усны эх үүсвэр нь тухайн өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох чухал үзүүлэлтийн нэг.

Судалгаанд хамрагдсан өрхийн сууцны халаалтын төрлийг авч үзвэл, 37.9 хувь нь төвлөрсөн системд холбогдсон, 1.3 хувь нь цахилгаан халаагууртай, 3.1 хувь нь нам даралтын зуухтай, 57.7 хувь нь ердийн галлагаатай өрх байна.


Хүснэгт 3.4. Өрхийн халаалтын төрөл, хот, хөдөө, хувиар, судалгаа, тооллогын дүнгээр

	ЦАС, 2015 он			ХАОСТ, 2015* он		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн систем	22.9	37.9	5.9	25.8	37.0	2.8
Цахилгаан халаагуур	1.0	1.3	0.7	1.9	2.3	1.1
Нам даралтын зуух	2.2	3.1	1.2	0.6	0.8	0.3
Ердийн галлагаа	74.3	57.7	92.2	71.6	59.9	95.9

*- Хүн ам, орон сууцны завсрын тооллого

Өрхийн халаалтын төрлийг бүсээр авч үзвэл, Хангайн болон Баруун бүсэд төвлөрсөн систем болон нам даралтад зуухын хэрэглээ бага, ердийн галлагаатай өрхийн эзлэх хувь өндөр байгаа нь дараах зургаас ажиглагдаж байна.

Зураг 3.5. Өрхийн халаалтын төрөл, бүсээр, хувиар



Улаанбаатар хотын өрхийн 46.4 хувь нь ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон сууцны, 33.7 хувь нь ус түгээх байрны ус хэрэглэдэг байна. Төвийн бүсийн өрхийн 20.3 хувь, Зүүн бүсийн 12.2 хувь нь ус хангамжийн шугам шүлжээнд холбогдсон байна.

Баруун (43.7 хувь) болон Зүүн (45.5 хувь) бүсийн өрхийн ундны усны гол эх үүсвэр нь хамгаалсан гүний худаг, Хангайн (27.8 хувь) бүсийнх зөөрийн усны үйлчилгээ, Төвийн бүсийнх (23.1 хувь) ус түгээх байр байна.

Хүснэгт 3.5. Өрхийн ундны усны эх үүсвэр, бүсээр, хувиар

Үзүүлэлт	Бүс					Улсын дүн
	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар	
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ус хангамжийн шугам сүлжээ	6.6	5.5	20.3	12.2	46.4	21.9
Ус түгээх байр	9.0	9.6	23.1	12.0	33.7	19.8
Хамгаалсан гүний худаг	43.7	15.5	16.8	45.5	15.6	24.5
Хамгаалсан булаг	0.3	2.4	0.2	0.5	0.4	0.8
Зөөврийн усны үйлчилгээ	3.9	27.8	9.0	8.3	3.2	10.1
Ус зөөврийн ердийн хөсөг	-	1.8	3.5	0.4	0.1	1.1
Хамгаалаагүй гар худаг	8.3	19.0	20.5	15.8	0.1	11.4
Хамгаалаагүй булаг	5.0	4.3	0.4	2.2	0.2	2.1
Усны ил эх үүсвэр	20.2	13.5	5.9	2.9	-	7.5
Хурын ус	2.7	0.5	-	0.2	-	0.6
Савласан ус	0.3	0.1	0.3	-	0.3	0.2

3.1.3 Судалгаанд хамрагдсан өрхийн хөрөнгийн байдал

Судалгаанд хамрагдсан өрхийн 36.7 хувь нь малтай, 32.1 хувь нь суудлын авто машинтай, 6.6 хувь нь хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхүүд байна.

Хөрөнгийн өмчийн байдлыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл, суудлын машинтай өрхийн 89.7 хувь, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхийн 81.5 хувь, малтай өрхийн 86.3 хувийг эрэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

Хүснэгт 3.6. Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгийн сонгосон үзүүлэлтээр, хувиар

Үзүүлэлт	Суудлын машинтай өрх	Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрх	Малтай өрх	Малын тоогоор						Өрхийн тоо
				<100	101-200	201-300	301-400	401-500	501<	
Бүгд	32.1	6.6	36.7	39.4	18.3	14.0	7.8	5.5	15.0	3 990
Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр										
Эрэгтэй	89.7	81.5	86.3	37.0	17.9	14.6	8.0	6.0	16.5	3 102
Эмэгтэй	10.3	18.5	13.7	54.2	21.4	9.9	7.0	2.0	5.5	888
Суурьшлаар										
Хот	63.6	35.1	11.8	64.2	18.5	8.1	2.9	1.7	4.6	2 068
Хөдөө	36.4	64.9	88.2	36.0	18.3	14.8	8.5	6.0	16.4	1 922


Эрэгтэй тэргүүлэгчтэй малтай өрхийн 37.0 хувь нь 100 хүртэлх малтай байгааг өмнөх 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 14.7 пунктээр, эмэгтэй тэргүүлэгчтэй малтай өрхийн 54.2 хувь нь 100 хүртэлх малтай болж, өмнөх судалгааны дүнгээс 16.7 пунктээр буурсан байна.

Судалгааны дүнгээс харахад 200 хүртэлх малтай өрхийн тоо өмнөх судалгааны дүнгээс буурч, 200-аас дээш малтай өрхийн тоо өссөнд нийт малын тоо 2015 онд 56.0 саяд хүрч, 2011 оноос 54.1 хувиар өссөн нөлөөлсөн.

Суудлын машинтай өрхийн тоо өмнөх 2011 оны судалгааны үр дүнгээс 4.9 пунктээр өсч 32.1

хувь болсон бол хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхийн эзлэх хувь өмнөх судалгааны дүнгээс 4.2 пунктээр буурч 6.6 хувьд хүрсэн байна. Суудлын машинтай өрхийн 63.6 хувь нь хотод, харин малтай өрхийн 88.2 хувь нь хөдөөд байгаа нь хөрөнгө санхүү, аж ахуйн эрхлэлтэнд хот, хөдөөгийн ялгаа их байгааг харуулж байна. Мөн суудлын машинтай өрхийн 44.0 хувь нь Улаанбаатар хотод байна. Энэ нь Улаанбаатар хотын хотжилт, суурьшмал байдал, амьдралын хэв маяг, амьдралын түвшин сайжирсан зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байж болно.


Зураг 3.6. Судалгаанд хамрагдсан өрх, малын тоогоор, хувиар, судалгааны дүнгээр



Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96.0 хувь нь өрхийн гишүүд нь гар утас хэрэглэдэг, 95.4 хувь нь телевизортой, 74.5 хувь нь хөргөгч, хөлдөөгчтэй, 67.0 хувь нь угаалгын машинтай байна. Хотын өрхийн 98.3 хувийнх нь, хөдөөгийн өрхийн 93.5 хувийнх нь өрхийн гишүүд гар утас хэрэглэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хотод 35.1 пунктээр, хөдөөд 56.7

пунктээр өссөн байна. Мөн телевизортой өрхийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад хотод 98.5 хувь болж 5.3 пунктээр, хөдөөд 92.1 хувь болж 55.3 пунктээр өссөн байна. Өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад нийт өрхөд гэр ахуйн цахилгаан бараа хэрэглэдэг өрхийн тоо өссөн байгаа бөгөөд энэ өсөлт хөдөө орон нутагт өндөр байна.


Зураг 3.7. Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгөөр, байршлаар, хувиар



Тээврийн хэрэгсэлтэй өрхийн мэдээллийг авч үзэхэд 32.1 хувь нь суудлын авто машинтай, 24.3 хувь нь мотоциклтой, 12.6 хувь нь ачааны машинтай, 2.3 хувь нь ердийн хөсөгтэй, 2.1 хувь нь трактортой, 1.8 хувь нь автобус болон микро автобустай гэсэн байна. Бүсээр авч үзэхэд суудлын

авто машинтай өрхийн 41.1 хувь нь Улаанбаатар хотод, ачааны авто машинтай өрхийн 35.9 хувь нь Төвийн бүсэд, мотоциклтэй өрхийн 40.1 хувь нь Хангайн бүсэд байгаа нь бусад бүсээс өндөр хувьтай байна.

Зураг 3.8. Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгөөр, бүсээр, хувиар




3.1.4 Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн бүтэц, боловсролын түвшин

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын 25.9 хувь нь 0-11 насны хүүхэд, 9.6 хувь нь 12-17 насны өсвөр насныхан, 64.5 хувь нь 18, түүнээс дээш насныхан байна. 2015 оны хүн ам, орон сууцны

завсрын тооллогын дүнгээр хүн ам зүйн ачаалал 51.3 хувь байсан бол энэ судалгааны дүнгээр 54.7 хувь байна.

Судалгаанд хамрагдагчдын 48.5 хувь нь эрэгтэйчүүд, 51.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3.9. Судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн бүтэц, хувиар



Насны бүлгээр тооцсон хүйсийн харьцааг харахад нас ахих тусам хүйсийн харьцаа алдагдсаар 70, түүнээс дээш насанд 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо буурч байна. Энэ нь эрэгтэй хүүхдүүд илүү олон төрөөд, нас ахих тусам эрэгтэйчүүдийн тоо цөөрч, эмэгтэйчүүд давамгайлдаг нийтлэг хандлага манай улсад ч байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан 12, түүнээс дээш насны хүн амын 4.9 хувь нь боловсролгүй, 95.1 хувь нь аль нэг шатны боловсрол эзэмшсэн байна.

Боловсрол эзэмшсэн хүн амын 1.2 хувь нь магистр, доктор, 17.8 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 5.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 8.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 27.0 хувь нь бүрэн дунд, 21.8 хувь нь суурь, 13.7 хувь нь бага боловсролтой хүмүүс байна. Судалгаанд хамрагдагчдын боловсролын түвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр болж байна.

Магистр, доктор, дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүн амын 61.4 хувийг эмэгтэйчүүд, 38.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 3.10. Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин, хүйсээр, хувиар



Боловсролгүй хүн амын 23.6 хувь нь хотод, 76.4 хувь нь хөдөөд, магистр болон докторын боловсролтой хүн амын 96.4 хувь нь суурин газарт амьдарч байна.

Дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр байна. Энэ нь их дээд сургуулиуд нийслэлд

төвлөрсөн, төгсөгчид ихэвчлэн Улаанбаатар хотод суурьших, ажиллах хүсэлтэй байдагтай холбоотой юм.

Тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүний эзлэх хувь Төвийн бүсэд хамгийн өндөр байгаа бол Хангай болон Баруун бүсэд бага байна.

Хүснэгт 3.7. Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, байршил, бүсээр, хувиар

Үзүүлэлт	Боловсролын түвшин								Хүний тоо
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор	
Бүгд	4.9	13.7	21.8	27.0	8.6	5.0	17.8	1.2	10 091
Хүйс									
Эрэгтэй	5.4	14.6	23.8	26.4	10.4	4.1	14.2	1.1	4 867
Эмэгтэй	4.4	12.9	19.9	27.6	7.0	5.7	21.2	1.3	5 224
Суурьшил									
Хот	2.3	8.4	14.8	30.0	11.0	5.6	25.8	2.1	5 170
Хөдөө	7.7	19.3	29.1	23.8	6.1	4.3	9.4	0.3	4 921
Байршил									
Нийслэл	1.4	6.8	11.9	27.9	12.8	5.5	30.7	3.0	2 945
Аймгийн төв	3.4	10.5	18.7	32.9	8.6	5.7	19.4	0.8	2 225
Сумын төв	4.4	14.0	24.0	28.5	7.3	6.0	15.4	0.4	2 413
Хөдөө	10.9	24.4	34.1	19.2	5.0	2.6	3.7	0.1	2 508
Бүс									
Баруун	7.6	17.6	24.1	27.8	3.8	4.6	13.9	0.6	1 761
Хангай	6.1	24.4	30.7	22.1	4.5	2.6	9.2	0.4	1 966
Төв	5.1	10.3	24.1	28.4	9.0	6.6	16.0	0.5	2 021
Зүүн	6.9	13.5	24.0	28.9	11.2	4.9	10.5	0.1	1 398
Улаанбаатар	1.4	6.8	11.9	27.9	12.8	5.5	30.7	3.0	2 945

3.1.5 Судалгаанд хамрагдсан хүн амын гэрлэлтийн байдал

Судалгаанд 15, түүнээс дээш насны 9437 хүн хамрагдсанаас 27.5 хувь нь огт гэрлээгүй, 55.3 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 5.7 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 1.5 хувь нь гэр бүл тусгаарласан, 1.9 хувь нь гэрлэлтээ цуцалсан, 8.1 хувь нь бэлбэсэн хүмүүс байна.

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 31.6 хувь, эмэгтэйчүүдийн 23.8 хувь нь огт гэрлээгүй байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол


эрт гэр бүлтэй болдогтой холбоотой байх. Харин эрэгтэйчүүдийн 1.3 хувь нь гэр бүл тусгаарласан, 1.6 хувь нь гэрлэлтээ цуцалсан, 3.1 хувь нь бэлбэсэн хүмүүс байгаа бол эмэгтэйчүүдийн 1.6 хувь нь тусгаарласан, 2.2 хувь нь цуцалсан, 12.7 хувь нь бэлбэсэн хүмүүс байна. Бэлбэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол дахин гэр бүл болох нь бага нөгөө талаас эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс өндөр байдагтай холбоотой байх талтай.

Хүснэгт 3.8. Хүн амын гэрлэлтийн байдал, хүйсээр, хувиар

Гэрлэлтийн байдал	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	9 437	100.0	4 560	100.0	4 877	100.0
Огт гэрлээгүй	2 602	27.5	1 439	31.6	1 163	23.8
Батлуулсан гэр бүлтэй	5 215	55.3	2 598	57.0	2 617	53.7
Батлуулаагүй гэр бүлтэй	540	5.7	247	5.4	293	6.0
Тусгаарласан	137	1.5	61	1.3	76	1.6
Цуцалсан	181	1.9	74	1.6	107	2.2
Бэлбэсэн	762	8.1	141	3.1	621	12.7


Судалгаанд хамрагдсан хөдөөгийн хүн амын 57.0 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 28.9 хувь нь огт гэрлээгүй бол хотын хүн амын 53.6 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 26.4 хувь нь огт гэрлээгүй байна.

Зураг 3.11. Судалгаанд хамрагдсан хүн амын гэрлэлтийн байдал, бүсээр, хувиар



Огт гэр бүл болоогүй хүн ам бусад бүсээс Баруун бүсэд хамгийн их буюу 31.6 хувь, гэр бүлтэй хүн ам мөн тухайн бүсэд хамгийн бага буюу 59.2 хувьтай байна.

Зураг 3.12. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, хувиар



3.2 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

3.2.1 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлт

Эдийн засгийн идэвхтэй хүн амд тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулдаг. Цаг ашиглалтын судалгаагаар ч судалгаанд хамрагдсан хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, ажилласан цаг, ажиллагчдын дундаж цалингийн талаар сонирхож судалсан болно.

Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны 9437 хүн байгаагийн 5897 буюу 62.5 хувь нь эдийн засгийн идэвхтэй, 3540 буюу 37.5 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг бүтцээр нь авч үзэхэд 5273 хүн буюу 89.4 хувь нь ажиллагчид, 624 хүн буюу 10.6 хувь нь ажилгүй иргэд байна.


Цаг ашиглалтын судалгаагаар ажиллах хүчний оролцооны түвшин 62.5 хувь байна.

Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.9 хувь, ажилгүйдлийн түвшин 10.6 хувьтай байна. Харин хотод ажилгүйдлийн түвшин улсын түвшинд байхад хөдөөд улсын түвшнээс 0.1 пунктээр бага буюу 10.5 хувь байна.

Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны нийт ажиллагчдын 45.7 хувь нь хотод, 54.3 хувь нь хөдөөд ажиллаж байна.

Нийт ажиллагчдын 48.0 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 33.7 хувь нь мал аж ахуй эрхлэгчид, 16.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Зураг 3.13. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар



Хотын ажиллагчдын 71.5 хувь нь цалин хөлстэй ажиллагчид, 21.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байгаа бол хөдөөгийн ажиллагчдын 28.1 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 12.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 58.8 хувь нь мал аж ахуй эрхлэгч байна. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдын 73.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 56.7 хувь нь хотод, 43.3 хувь нь хөдөөд байна.

Судалгаагаар нийт 5273 ажиллагчдын 2.3 хувь нь давхар ажил эрхэлдэг бөгөөд тэдний 41.5 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 30.1 хувь нь хувиараа

хөдөлмөр эрхлэгч, 26.8 хувь нь мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч болон ажил олгогч тус бүр 0.8 хувь байна. Давхар ажил эрхлэгчдийн 39.0 хувь нь эмэгтэйчүүд, 61.0 хувь нь эрэгтэйчүүд байна.

Давхар ажил эрхлэгчдийн 25.2 хувь нь хотод, 74.8 хувь нь хөдөөд байна. Хөдөөд эрэгтэйчүүд ихэвчлэн хувиараа хөдөлмөр эрхлэх, цалин хөлстэй ажиллах, мал аж ахуй эрхэлж байна.

3.2.2 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны ажиллагчдын дундаж цалин, хөлс, орлого

Судалгаагаар 15, түүнээс дээш насны нийт 5273 ажиллагчид байгаагаас мал аж ахуй эрхлэгч болон өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдоос бусад ажиллагчид 3466 байна. Эдгээр ажиллагчдын сарын дундаж цалин, хөлс, орлого улсын дунджаар 575.9 мянга, эрэгтэйчүүдийнх 608.6 мянга, эмэгтэйчүүдийнх 538.8 мянган төгрөг байна.

Ажиллагчдын 20.6 хувь нь 250.0-400.0 мянган төгрөг, 37.6 хувь нь 400.0-600.0 мянга, 32.5 хувь нь 600.0 мянган төгрөгөөс дээш дундаж цалинтай байна. Харин 9.3 хувь нь 250.0 мянган төгрөгөөс доош дундаж цалинтай байна. Ажиллагчдын дундаж цалинг хүйсээр авч үзэхэд, 600.0 мянган төгрөгөөс дээш цалин авдаг ажиллагчдын дотор эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс илүү байна.

Хүснэгт 3.9. Сарын дундаж цалингийн бүтэц, хот, хөдөө, хүйсээр, хувиар

Цалингийн интервал	Хот		Хөдөө		Улсын дундаж		
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
<80.000	0.9	1.2	4.6	4.3	2.2	2.1	0.5
80.001-150.000	1.3	1.3	8.9	7.8	3.8	3.5	2.1
150.001-250.000	4.8	7.7	12.6	12.2	7.5	9.2	6.7
250.001-400.000	15.9	21.4	24.3	26.5	18.7	23.1	20.6
400.001-600.000	34.7	37.7	27.6	35.9	32.3	37.1	37.6
600.001<	42.4	30.7	22.0	13.3	35.5	25.0	32.5

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад сарын дундаж цалин улсын дунджаар 2.4 дахин, хотод дундаж цалин 1.9 дахин, хөдөөд 3.6 дахин өссөн байна.

Хүснэгт 3.10. Сарын дундаж цалин, байршлаар, хүйсээр, судалгааны дүнгээр

	Хот		Хөдөө		Улсын дүн	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
ЦАС, 2007 он	181.0	146.6	79.5	39.0	130.2	94.0
ЦАС, 2011 он	361.0	308.0	134.0	121.0	251.0	220.0
ЦАС, 2015 он	676.9	589.1	475.7	437.9	608.6	538.8
Өсөлтийн хувь						
/2007/	3.7	4.0	6.0	11.2	4.7	5.7
/2011/	1.9	1.9	3.6	3.6	2.4	2.4

Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд, эрэгтэйчүүдийн цалин ажил мэргэжлийн төрөлд эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Зураг 3.14. Сарын дундаж цалин, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, мянган төгрөгөөр



3.2.3 Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам

Судалгаагаар 15, түүнээс дээш насны хүн амын 3540 буюу 37.5 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Эдгээр эдийн засгийн идэвхгүй хүн амын 33.1 хувь нь суралцдаг, 30.3 хувь нь тэтгэвэрт гарсан, 13.0 хувь нь хүүхэд харсан шалтгааны улмаас эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохгүй

байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын 61.2 хувь нь эмэгтэйчүүд, 38.8 хувь нь эрэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амыг хүйсээр авч үзэхэд хүүхэд асарсан арван хүний ес нь, өвчтөн, өндөр настан асарсан арван хүний зургаа нь, гэрийн ажил хийсэн арван хүний долоо нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 3.11. Судалгаанд хамрагдсан эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаан, хүйс, хот, хөдөөгөөр, хувиар

	Хот		Хөдөө		Улсын дундаж		
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Суралцдаг	33.5	25.2	49.3	35.0	39.9	28.7	33.1
Тэтгэвэрт	29.6	34.9	20.4	30.3	25.8	33.2	30.3
Өвчтэй байсан	5.2	1.9	3.7	1.8	4.6	1.9	2.9
Хөгжлийн бэрхшээлтэй	9.4	4.6	7.5	4.8	8.6	4.7	6.2
Хүүхэд асардаг	2.2	22.6	0.9	15.6	1.7	20.1	13.0
Өндөр настай	0.4	0.1	0.2	0.1	0.3	0.1	0.2
Ажил хийхийг хүсдэггүй	2.2	0.6	1.4	0.6	1.9	0.6	1.1
Өвчтөн, өндөр настан асардаг	2.0	1.9	0.5	1.4	1.4	1.7	1.6
Гэрийн ажилтай	3.6	5.0	2.3	6.2	3.1	5.4	4.5
Бусад	11.9	3.2	13.8	4.2	12.7	3.6	7.1

Эдийн засгийн идэвхгүй байгаа бусад шалтгааныг хүйсээр авч үзэхэд нилээд ялгаатай бөгөөд, тухайлбал, эрэгтэйчүүдийн 8.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй улмаас идэвхгүй байгаа

бол эмэгтэйчүүдийн 20.1 хувь нь хүүхэд асардаг учир идэвхгүй байна. Эдийн засгийн идэвхгүй байгаа эрэгтэйчүүдийн 1.9 хувь, эмэгтэйчүүдийн 0.6 хувь нь ажил хийхийг хүсээгүй байна.

Зураг 3.15. Судалгаанд хамрагдсан эдийн засгийн идэвхгүй хүн ам, голлох шалтгаан, хүйсээр, хувиар





**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЦАГ АШИГЛАЛТ**



4.1 ЦАГ АШИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ, ТӨЛӨВ БАЙДАЛ

Цагашиглалтын дүрзургийг гаргахдаа судалгаанд хамрагдсан хүн амыг Үндэсний тооцооны систем (ҮТС)-ийн хүрээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, цаг, долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан бүх цагт эзлэх хувиар буюу 24 цагийн 1440 минутаар тооцон гаргаснаас гадна эрэгтэй, эмэгтэйчүүд ямар үйл ажиллагааг зонхилон эрхэлж буйг харуулах зорилгоор нийт үйл ажиллагааг дараах байдлаар ангилан тооцсон болно. Үүнд:

1. ҮТС-ийн хүрээний үйл ажиллагаа буюу хөлстэй ажил эрхлэх
2. ҮТС-ийн хүрээний өргөтгөсөн үйл ажиллагаа буюу хөлсгүй ажил эрхлэх
3. ҮТС-ийн хүрээний бус үйл ажиллагаа буюу өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа.

Мөн хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүн амын насны 5 бүлгүүдээр ангилан тооцов. Үүнд:

1. Насанд хүрэгчид (18 ба түүнээс дээш нас)
2. Хөдөлмөрийн насны хүн ам

3. Хүүхэд (12-17 нас)
4. Залуучууд (15-24 нас)
5. Өндөр настан

4.1.1 Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг

а. Ерөнхий төлөв


Улсын дунджаар Монгол хүн долоо хоногийн нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд 321 минут буюу бараг 5 цаг 21 минутыг, хөлсгүй ажил эрхлэхэд 186 минут буюу 3 цагийг зарцуулж байна. Түүнчлэн Монгол хүмүүсийн хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг ашиглалтанд хот, хөдөөгийн ялгаа ажиглагдаж байна (Хүснэгт 4.1). Хотын хүмүүс хөлстэй хөдөлмөр эрхлэхэд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 268 минут буюу 4 цаг 28 минутыг зарцуулж байхад хөдөөгийн хүмүүс 379 минут буюу 6 цаг 19 минутыг зарцуулж байгаа нь мал аж ахуйн холбогдолтой ажил эрхэлж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл хөдөөгийн хүмүүсийн хөлстэй ажил эрхлэх нийт үйл ажиллагааны 60.4 хувийг мал аж ахуйн холбогдолтой үйл ажиллагаа эзэлж байна.

Хүснэгт 4.1. Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар

	Үйл ажиллагаа	Хот	Хөдөө	Улсын дундаж
Бүгд		1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа		268	379	321
	Байгууллагад ажил эрхлэх	186	76	133
	Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)	26	258	138
	Үүнээс:			
	Мал аж ахуй	15	229	118
	Өрхөөр болон хувиараа анхан шатны бус боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	6	10	8
	Өрхөөр болон хувиараа барилгын ажилд оролцох	2	3	3
	Орлого олох зорилготой өрхийн худалдаа үйлчилгээ эрхлэх	9	9	9
	Ажилтай холбоотой явах	39	23	30
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа		188	183	186
	Өрх гэрийн ажил, нүүдэл	140	147	144
	Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	46	31	38
	Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	2	5	4
ҮТС-ийн бус үйл ажиллагаа		984	878	933
	Боловсрол сургалтын үйл ажиллагаа	46	25	36
	Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	27	24	26
	Чөлөөт цаг, спорт	156	126	141
	Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	755	703	730

2015 оны судалгааны дүнгээр хөлстэй ажил эрхлэхэд эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт 391 минут, хөлсгүй ажил эрхлэхэд 97 минутыг зарцуулсан нь өмнөх 2011 оны судалгааны дүнгээс хөлстэй ажил эрхэлсэн хугацаа бараг нэг цаг буюу 43 минутаар нэмэгдэж, хөлсгүй ажил эрхэлсэн хугацаа 42 минутаар буурсан байна.

Зураг 4.1. Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр



Харин хөлстэй ажил эрхлэхэд эмэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт 266 минут, хөлсгүй ажил эрхлэхэд 256 минутыг зарцуулж байгаа нь өмнөх судалгааны дүнгээс хөлстэй ажил эрхэлсэн хугацаа 28 минутаар өсч, хөлсгүй ажилд зарцуулсан хугацаа 34 минутаар буурсан дүн гарлаа (Зураг 4.1).

Эрэгтэйчүүд хөлстэй ажил зонхилон эрхэлж, эмэгтэйчүүд хөлсгүй ажилд эрэгтэйчүүдээс илүү цаг зарцуулж байгаа нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд хүйс харгалзахгүйгээр долоо хоногийн нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа бараг хэвийн түвшинд, харин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулж буй цаг хугацаа нэмэгдэж байгаа хандлага ажиглагдаж байна.

б. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан хүн амын нэг өдөрт хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан цаг, хүйс болон хот, хөдөөгөөр ялгаатай байна (Зураг 4.2). Тухайлбал, улсын дунджаар эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 27.2 хувийг зарцуулж байхад эмэгтэйчүүд 18.5 хувийг л тус ажилд зарцуулж байна.

Зураг 4.2. Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр



- Байгууллагад ажил эрхлэх
- Өрхөөр болон хувиараа анхан шатны үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)
- Өрхөөр болон хувиараа анхан шатны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх
- Ажилтай холбоотой явах

Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаатай холбоотой явах замд улсын дунджаар эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 2.4 хувийг, эмэгтэйчүүд 1.9 хувийг зарцуулжээ. Ажилтай холбоотой явах замд зарцуулах хугацаа хотынх хөдөөнийхнөөс илүү цагийг зарцуулж байгаа нь дээрх зургаас харагдаж байна.


Хотын эрэгтэй, эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 11.2-15.4 хувийг байгууллага болон хувь хүнд ажил эрхлэхэд зарцуулж байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд нийт цагийн 23.6 хувийг өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл (ХАА ороод) эрхлэхэд зарцуулж байгаа бол хөдөөгийн эмэгтэйчүүд нийт цагийн зөвхөн 12.8 хувийг л тус ажилд зарцуулж байна.

в. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Гэр ахуйн ажлыг эмэгтэйчүүд зонхилон хийдэг нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал, энэ ажилд эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 14.1 хувь буюу 203 минутыг, эрэгтэйчүүд ердөө 4.8 хувь буюу 69 минутыг л зарцуулж байна.

Өрхийн гишүүд болох хүүхэд, өндөр настан болон өвчтэй хүн асрах ажилд эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 3.5 хувь буюу 51 минутыг зарцуулдаг бол эрэгтэйчүүд 1.6 хувь буюу 23 минутыг л зарцуулж байна.

Зураг 4.3. Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр



г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Улсын дунджаар эрэгтэй, эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 2.4-2.6 хувь буюу 34-37 минутыг сурч боловсроход зарцуулж байна. Харин хүмүүстэй харилцах болон шашны зан үйлийн ажиллагаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 1.7-1.9 хувийг зарцуулж байна (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2. Долоо хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Боловсрол сургалтын үйл ажиллагаа	44	48	25	25	34	37
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	28	26	25	24	27	25
Чөлөөт цаг, спорт	181	139	137	115	158	128
Үүнээс:						
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	146	115	115	98	130	107
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	756	754	711	697	733	728
Дүн	1009	967	898	861	952	918

Чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цагийг зарцуулж байна. Чөлөөт цаг, спортын үйл ажиллагааны 80 –аас дээш хувийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ эзэлж, түүн дотроо хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Эрэгтэйчүүд ном, сонин унших, радио сонсох, телевиз үзэх, интернэтэд орох зэрэг ажилд өдрийн нийт цагийнхаа 9.0 хувь буюу 130 минутыг зарцуулдаг бол эмэгтэйчүүд 7.4 хувь буюу 107 минутыг зарцуулж байна.

Эрэгтэй, эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 51 хувийг унтах, амрах, хооллох, хувийн ариун цэвэр сахих, бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбоотой тусламж, үйлчилгээ авахад зарцуулжээ. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдсан хүмүүс хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд цагаа зонхилон зарцуулж байна.


4.1.2 Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг

а. Ерөнхий төлөв

Өдөрт ажлын найман цаг буюу 480 минут байдгийг харгалзан үзвэл, улсын дунджаар Монгол хүн хөлстэй ажил эрхлэхэд ажлын нэг өдөрт 6 орчим цаг буюу 335 минутыг зарцуулж байгаа нь ажлын цагийн 69.8 хувьтай тэнцэж байна (Хүснэгт 4.3). Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд хөдөөний хүн ам хотынхоос бараг 2 цагаар илүү буюу 382 минутыг зарцуулж байна. Харин хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд хүмүүсийн байршлын ялгаа бараг байхгүй, 3 орчим цагийг ажлын өдөрт зарцуулсан байна.

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд ажлын нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд 401 минут буюу ажлын цагийн 83.5 хувийг эзэлж байна. Хөлсгүй ажил эрхлэхэд 94 минут зарцуулж байгаа нь 2011 оны судалгааны дүнгээс хөлстэй ажил эрхэлсэн хугацаа 8.7 хувь буюу 42 минутаар өсч, хөлсгүй ажил эрхэлсэн хугацаа 39 минутаар буурсан байна.

Зураг 4.4. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр



Ажлын нэг өдөрт эрэгтэйчүүдийн хөлстэй ажил эрхэлсэн цаг өмнөх судалгааны дүнгээс 42 минутаар нэмэгдсэн нь хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан цаг 39 минутаар буурсантай холбоотой, харин өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулсан цаг өмнөх оны судалгаануудын түвшинд байна (Зураг 4.4).

б. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Хотын эрэгтэйчүүд байгууллага болон хувь хүнд хөлстэй ажил эрхлэхэд ажлын нэг өдөрт 4 цаг

Хүснэгт 4.3. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот	Хөдөө	Улсын дундаж
Бүгд	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	292	382	335
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	177	180	179
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	971	878	926

Ажлын нэг өдөрт эмэгтэйчүүд хөлстэй ажил эрхлэхэд 283 минут зарцуулж байгаа нь нийт ажлын цагийн 58.9 хувьтай тэнцэж байна. Эмэгтэйчүүд хөлсгүй ажил эрхлэхэд 246 минут зарцуулж байгаа нь өмнөх судалгааны дүнгээс хөлсгүй ажил эрхэлсэн хугацаа 30 минутаар буурч, хөлстэй ажил эрхэлсэн хугацаа 2 минутаар нэмэгджээ.

зарцуулж байгаа бол эмэгтэйчүүд 3 цаг зарцуулж байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд ажлын нэг өдөрт өрхөөрөө болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл (ХАА ороод) эрхлэхэд 5.6 цаг зарцуулж байгаа бол эмэгтэйчүүд энэ ажилд 3 цаг зарцуулж байна. Эндээс дүгнэхэд хөдөөд амьдарч буй эрэгтэйчүүд хотын эрэгтэйчүүдээс ажлын нэг өдөрт илүү их ажиллаж, хөдөлмөрлөж байна (Зураг 4.5).

Зураг 4.5. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хот, хөдөө, хүйсээр




Хөлстэй ажил эрхлэхтэй холбоотойгоор ажилдаа ирж очих замд хот, суурин газарт 39-48 минутыг, хөдөө орон нутагт 20-28 минутыг зарцуулж байна.

в. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Өрх гэрийн ажил эрхлэхэд эмэгтэйчүүд өдөрт бараг 3 цаг 20 минут буюу өдрийн нийт цагийнхаа 13.4 хувийг зарцуулдаг бол эрэгтэйчүүд өдөрт ердөө 1 цаг буюу өдрийн нийт цагийн 4.6 хувийг энэ ажилд зарцуулдаг байна (Зураг 4.6).

Зураг 4.6. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр



Хүүхэд, өндөр настан, өвчтэй байгаа өрхийн гишүүдийг асрах үйл ажиллагаанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2 дахин илүү цагийг зарцуулж байна.

Бусад өрх хүмүүст туслах, олон нийтийн зохион байгуулалттай болон сайн дурын ажилд оролцоход эмэгтэй, эрэгтэйчүүд ажлын өдөрт 2-5 минутыг зарцуулж байна.

г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан хотын эрэгтэй, эмэгтэйчүүд ажлын өдрийн нийт цагийнхаа 3.7-4.0 хувийг сурч боловсрох үйл ажиллагаанд зарцуулдаг бол хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүд 1.9-2.1 хувийг зарцуулж байна.

Зураг 4.7. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр



4.1.3 Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын зарцуулсан цаг

а. Ерөнхий төлөв

Улсын дунджаар Монгол хүн амралтын нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд 285 минут, хөлсгүй ажилд 204 минутыг зарцуулсан байна. Түүнчлэн Монгол хүмүүсийн амралтын өдөрт хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг ашиглалтанд хот, хөдөөгийн ялгаа ажиглагдаж байна.


Хүснэгт 4.4. Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот	Хөдөө	Улсын дундаж
Бүгд	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	204	371	285
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	219	188	204
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1017	881	951

Хөдөөнийхөн амралт, ажлын өдөр гэсэн ялгаа байхгүйгээр өдөрт хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд 6 цагийг (ажлын өдөр 382 минут, амралтын өдөр 371 минут) зарцуулж байгаа нь харагдаж байна (Хүснэгт 4.3, 4.4).

Эрэгтэйчүүд амралтын нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд 363 минут, хөлсгүй ажил эрхлэхэд 107 минут зарцуулж байгаа нь өмнөх судалгааны дүнгээс хөлстэй ажил эрхэлсэн хугацаа 41 минутаар нэмэгдэж, хөлсгүй ажил эрхэлсэн хугацаа 45 минутаар буурсан байна (Зураг 4.8).

Зураг 4.8. Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр



Тэгвэл эмэгтэйчүүд хөлстэй ажил эрхлэхэд 222 минут буюу өдрийн нийт цагийнхаа 15.4 хувийг, хөлсгүй ажил эрхлэхэд 281 минут буюу өдрийн нийт цагийнхаа 19.5 хувийг зарцуулж байгаа нь өмнөх судалгааны дүнгээс хөлстэй ажил эрхэлсэн хугацаа 19 минутаар нэмэгдэж, хөлсгүй ажил эрхэлсэн хугацаа 41 минутаар буурсан байна.

б. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг ашиглалтанд хот, хөдөөгийн ялгаа харагдаж байна.

Зураг 4.9. Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйс, хот, хөдөөгөөр



Тухайлбал, хот суурин газарт амьдарч байгаа эрэгтэйчүүд амралтын нэг өдөрт цалин хөлстэй ажил эрхлэхэд 174 минут зарцуулдаг бол эмэгтэйчүүд 99 минут зарцуулж байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд амралтын нэг өдөрт өрхөөрөө болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд 355 минутыг зарцуулж байгаа бол хөдөөгийн эмэгтэйчүүд энэ ажилд 191 минут зарцуулж байна (Зураг 4.9).

в. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Амралтын нэг өдөрт өрх гэрийн ажил болон нүүх үйл ажиллагаанд хот, хөдөөгийн эмэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 15.6-16.1 хувийг зарцуулж байхад эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 4.7-6.3 хувийг энэ ажилд зарцуулдаг байна (Зураг 4.10).

Зураг 4.10. Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЦАГ АШИГЛАЛТ

г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Эмэгтэйчүүд сурч боловсрох үйл ажиллагаанд эрэгтэйчүүдээс илүү цаг хугацааг зарцуулж байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 4.5. Амралтын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөө, хүйсээр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 050	994	895	868	970	937
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	18	24	13	16	16	20
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	32	30	25	24	28	27
Чөлөөт цаг, спорт	213	154	141	122	176	140
Үүнээс:						
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	170	128	116	101	115	127
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	787	786	716	706	750	750

Хүмүүстэй харилцах, олон нийтийн газар үзвэр үзэх, чөлөөт цагийн үйл ажиллагаанд хотын эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 7.5 хувийг, хөдөөгийн эрэгтэйчүүд 5.3 хувийг зарцуулдаг байна.

Ном, сонин унших, радио сонсох, телевиз үзэх, интернэтэд орох зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээнд хотын хүмүүс хөдөөгийн хүмүүсээс илүү цагийг зарцуулж байна. (Хүснэгт 4.5).


4.2 НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЦАГ АШИГЛАЛТ

4.2.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг

а. Ерөнхий төлөв

18 ба түүнээс дээш насны хүмүүсийг насанд хүрсэн хүн ам гэж үзэв. Улсын дунджаар насанд хүрсэн эрэгтэйчүүд хөлстэй ажил эрхлэхэд өдөрт 417 минут, хөлсгүй ажил эрхлэхэд 99 минут, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа эрхлэхэд 924 минутыг зарцуулсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан хугацаа 35 минутаар нэмэгдэж, хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан хугацаа 42 минутаар буурч, харин өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа өмнөх судалгаануудын түвшинд байна.

Зураг 4.11. Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр



Эмэгтэйчүүд хөлсгүй ажил эрхлэхэд 265 минут зарцуулж 35 минутаар буурсан бол, хөлстэй ажил эрхлэхэд 283 минутыг зарцуулж 22 минутаар нэмэгдсэн байна (Зураг 4.11).

Хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг сүүлийн жилүүдэд өсч байгааг судалгааны дүн харуулж байна. 2015 онд энэхүү үйл ажиллагаанд эрэгтэйчүүд

7 цаг, эмэгтэйчүүд 5 цагийг зарцуулж байгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад тус бүр нэг нэг цагаар нэмэгджээ.

Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд хөдөө орон нутгийнхан хотынхныг бодоход илүү олон цаг зарцуулж байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 4.6. Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар


Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 440	1 440	1 440	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	349	249	480	323	417	283
Байгууллагад ажил эрхлэх	246	177	82	84	161	135
Өрхөөр болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)	37	18	354	190	202	97
Үүнээс:						
Мал аж ахуй	24	10	354	190	202	97
Үйлчилгээ, худалдаа болон бусад үйлдвэрлэл эрхлэх	18	18	17	30	18	23
Ажилтай холбоотой явах	48	36	27	19	36	28
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	113	253	86	279	99	265
Өрх, гэрийн ажил, нүүдэл	79	191	62	232	70	210
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	30	60	17	45	23	53
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	2	7	2	6	2
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	978	938	874	838	924	892
Боловсрол сургалтын үйл ажиллагаа	18	26	5	8	11	18
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	29	26	26	25	28	25
Чөлөөт цаг, спорт	174	133	131	110	152	122
Үүнээс:						
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	170	123	112	100	140	112
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	170	123	112	100	140	112

Цалин хөлсгүй ажил эрхлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцооны хувьд хот, хөдөөгийн ялгаа байхгүй байна.

Насанд хүрсэн хүмүүсийн хувьд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа хот, хөдөөд ялгаатай байна. Тухайлбал, хотын насанд хүрсэн

эрэгтэйчүүд энэ үйл ажиллагаанд дунджаар 978 минут зарцуулж байгаа бол хөдөөгийн эрэгтэйчүүд 874 минутыг зарцуулсан байна. Энэ нь хөдөө орон нутагт амьдарч байгаа хүнд сурч боловсрох, үзвэр үйлчилгээ үзэх, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглах боломж хотыг бодвол хязгаарлагдмал байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 4.12. Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйс, хот, хөдөөгөөр



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд эрэгтэйчүүд өдөрт дунджаар 914 минут, эмэгтэйчүүд 892 минутыг зарцуулсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 7-14 минутаар нэмэгджээ.

Хөдөөгийн эрэгтэйчүүд нийт цагийнхаа 60.7 хувь буюу 874 минутыг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан бол эмэгтэйчүүдийн хувьд 58.2 хувь буюу 838 минутыг зарцуулсан.


Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хотын эрэгтэйчүүд нийт цагийнхаа 68.0 хувь буюу 978 минутыг зарцуулсан байхад эмэгтэйчүүд 65.1 хувь буюу 938 минутыг зарцуулсан байна (Зураг 4.12).

4.2.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг

Насанд хүрэгчдийн ажлын өдрийн цаг ашиглалтыг авч үзвэл, цалин хөлстэй ажилд эрэгтэйчүүд 430 минут, эмэгтэйчүүд 301 минутыг зарцуулсан нь эрэгтэйчүүд 129 минут буюу дунджаар 2 цагийг эмэгтэйчүүдээс илүү зарцуулсан болох нь харагдаж байна.

Өдөрт ажлын 8 цаг буюу 480 минут байдгийг харгалзан үзвэл, эрэгтэйчүүд нийт ажлын цагийн 89.6 хувийг, эмэгтэйчүүд 62.7 хувийг цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулж байна (Зураг 4.13).

Зураг 4.13. Насанд хүрэгчдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр




Насанд хүрсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.7 дахин их цаг хугацаа буюу 256 минутыг хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Ажлын нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд насанд хүрсэн эрэгтэйчүүд 914 минут, эмэгтэйчүүд 883 минутыг тус тус зарцуулжээ.


Хөдөөгийн насанд хүрсэн эрэгтэйчүүд ажлын нэг өдөрт цалин хөлстэй ажилд 482 минут, хотын эрэгтэйчүүд 375 минутыг зарцуулсан байна. Харин цалин хөлсгүй ажилд хотын эрэгтэйчүүд хөдөөгийн эрэгтэйчүүдээс 22 минутаар илүү буюу 107 минутыг зарцуулсан дүн гарчээ.

Зураг 4.14. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



Түүнчлэн ажлын нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хотын эрэгтэйчүүд 958 минут, хөдөөгийн эрэгтэйчүүд 873 минутыг зарцуулжээ. Тухайлбал, сурч боловсрох, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглах зэрэг үйл ажиллагаанд хотын эрэгтэйчүүд илүү цаг зарцуулж байна.

Зураг 4.15. Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр




Хөдөөгийн насанд хүрсэн эмэгтэйчүүд ажлын нэг өдөрт цалин хөлстэй ажил эрхлэхэд хотын насанд хүрсэн эмэгтэйчүүдээс илүү 1 цагийг (50 минут) зарцуулж байна (Зураг 4.15). Харин хотын эмэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хөдөөгийн эмэгтэйчүүдээс илүү цаг хугацаа зарцуулж байгаа нь дээрх зургаас харагдаж байна.

4.2.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг

Амралтын нэг өдөрт насанд хүрсэн эрэгтэйчүүд цалин хөлстэй ажил эрхлэхэд 383 минут буюу дунджаар 6 цаг зарцуулж байхад эмэгтэйчүүд 235 минут буюу 4 цаг зарцуулж байгаа нь эрэгтэйчүүд амралтын нэг өдөрт ч гэсэн эмэгтэйчүүдээс илүү цалин хөлстэй ажил хийж байгааг харуулж байна.

Зураг 4.16. Насанд хүрэгчдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр




Цалин хөлсгүй ажил эрхлэхэд насанд хүрсэн эрэгтэйчүүд 107 минут буюу дунджаар 2 орчим цаг зарцуулсан бол эмэгтэйчүүд 288 минут буюу дунджаар 5 цаг зарцуулж байгаа нь эмэгтэйчүүд амралтын нэг өдрөөрөө цалин хөлсгүй хөдөлмөрт илүү олон цагийг зарцуулдаг болохыг илэрхийлж байна.

Амралтын нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд насанд хүрсэн эрэгтэйчүүд 950 минут зарцуулсан бол эмэгтэйчүүд 917 минут буюу дунджаар 15 цаг зарцуулсан байна. Эдгээр үйл ажиллагаанд зарцуулах цагийн хувьд хүйсийн ялгаа байхгүй байна (Зураг 4.16).

Амралтын нэг өдөрт цалин хөлсгүй ажил эрхлэхэд хотын насанд хүрсэн эрэгтэйчүүд 128 минут, хөдөөгийн эрэгтэйчүүд 88 минутыг зарцуулсан бол хөдөөгийн эрэгтэйчүүд цалин хөлстэй ажил эрхлэхэд 477 минут, хотын эрэгтэйчүүд 284 минутыг зарцуулсан нь хөдөөгийн эрэгтэйчүүд голчлон мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой юм (Зураг 4.17). Харин өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд насанд хүрсэн хотын эрэгтэйчүүд хөдөөгийн эрчүүдээс бараг 3 цагаар илүү буюу 1028 минут зарцуулжээ.


Зураг 4.17. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



Хөдөөгийн насанд хүрсэн эмэгтэйчүүд амралтын нэг өдөрт цалин хөлстэй хөдөлмөрт 309 минут буюу хотын эмэгтэйчүүдээс 2 цаг илүү хугацаа зарцуулсан нь голчлон мал аж ахуйн холбогдолтой үйл ажиллагаа эрхэлсэнтэй холбоотой. Хотын эмэгтэйчүүд амралтын нэг өдөрт 175 минутыг хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Амралтын нэг өдөрт цалин хөлсгүй ажил эрхлэхэд хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ялгаа нэг их байхгүй ойролцоогоор 5 цагийг зарцуулжээ. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хотын эмэгтэйчүүд 974 минут, хөдөөгийн эмэгтэйчүүд 846 минутыг зарцуулсан байна (Зураг 4.18).

Зураг 4.18. Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр




4.3 ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ

4.3.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан дундаж цаг

Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүмүүс хүйс харгалзахгүйгээр хөлстэй ажил эрхлэх буюу ҮТС-ийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нэмэгдэж, харин хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан цаг буурсан байна (Зураг 4.19).

Зураг 4.19. Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, судалгааны дүнгээр



2015 онд хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд дунджаар 433 минут буюу 7 цаг, эмэгтэйчүүд 298 минут буюу 5 цагийг зарцуулж байгаа нь өмнөх судалгааны үеэс тус бүр нэг цагаар нэмэгджээ. Харин хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд өдөрт 95 минутыг зарцуулж өмнөх

үйеинхээс 38 минутаар, эмэгтэйчүүд 262 минутыг зарцуулж 22 минутаар тус тус буурсан байна.

Улсын дунджаар хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа гуравны нэг (30.1 хувь)-ийг, эмэгтэйчүүд тавны нэг (20.7 хувь)-ийг тус тус хөлстэй ажил эрхлэхэд зарцуулж байна.

Хүснэгт 4.7. Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 440	1 440	1 440	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	371	267	489	333	433	298
Байгууллагад ажил эрхлэх	267	196	87	91	172	147
Өрхөөр болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)	35	17	358	193	205	98
Үүнээс:						
Мал аж ахуй	22	10	316	172	176	85
Үйлчилгээ, худалдаа болон бусад үйлдвэрлэл эрхлэх	19	16	16	29	18	23
Ажилтай холбоотой явах	50	38	28	20	38	30
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	107	246	85	280	95	262
Өрх, гэрийн ажил, нүүдэл	75	182	61	232	67	205
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	28	62	17	46	22	55
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	2	7	2	6	2
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	962	927	866	827	912	880
Боловсрол сургалтын үйл ажиллагаа	30	39	11	15	21	27
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	27	23	24	22	26	22
Чөлөөт цаг, спорт	162	126	129	107	144	118
Үүнээс:						
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	133	105	111	93	122	100
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	743	739	702	683	721	713

Ажил эрхэлж буй хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 18.2 хувийг гэр орны ажил, өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах үйл ажиллагаанд зарцуулсан байна. Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд цалин хөлсгүй ажил эрхлэхэд улсын дунджаар эрэгтэйчүүдээс 2.8 дахин их цаг зарцуулж байгаа бол хот, хөдөөгөөр нь авч үзэхэд хотод 2.3, хөдөөд 3.3 дахин их цагийг зарцуулж байна (Хүснэгт 4.7).

Хөдөөд хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд хөлстэй ажил эрхлэхэд 333 минут, хотод 267 минут зарцуулсан байна. Тэд хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хотын эмэгтэйчүүдээс бага цаг зарцуулж байна. Энэ нь хөдөөд голчлон мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотой юм.

Хөлстэй ажил эрхлэхэд хөдөөгийн эрэгтэйчүүд өдөрт 489 минут, хотын эрэгтэйчүүд 371 минутыг зарцуулж, хөдөөгийн эрэгтэйчүүд хотын эрэгтэйчүүдээс 2 цагаар илүү энэ үйл ажиллагаанд оролцсон байна. Хөдөөгийн эрэгтэйчүүдийн нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан нийт цагийн 64.6 хувь, эмэгтэйчүүдийн 89.1 хувь нь хөдөө аж ахуйн салбар, түүн дотроо мал аж ахуйн холбогдолтой ажилд зарцуулсан гэсэн дүн гарч байна.

Хөлстэй ажил эрхлэхтэй холбоотойгоор ажилдаа ирэх, буцах замд хотынхон 38-50 минут, хөдөөнийхөн 20-28 минутыг зарцуулж байна.

Хүснэгт 4.8. Долоо хоногийн нэг өдөрт хөдөлмөрийн насны хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нийт дүнд эзлэх хувиар, хүйсээр

Үйл ажиллагаа	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	30.1	20.7
Байгууллагад ажил эрхлэх	11.9	10.2
Өрхөөр болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)	14.3	6.8
Үүнээс:		
Мал аж ахуй	12.2	5.9
Үйлчилгээ, худалдаа болон бусад үйлдвэрлэл эрхлэх	1.3	1.6
Ажилтай холбоотой явах	2.6	1.1
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	6.6	18.2
Өрх, гэрийн ажил, нүүдэл	4.7	14.2
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	1.5	3.8
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	0.4	0.1
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	63.3	61.1
Боловсрол сургалтын үйл ажиллагаа	1.5	1.9
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	1.8	1.5
Чөлөөт цаг, спорт	10.0	8.2
Үүнээс:		
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	8.5	6.9
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	50.1	49.5

Хотын хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэйчүүд 30-39 минутыг боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зарцуулж байхад хөдөөнийхөн харьцангуй бага 11-15 минутыг л зарцуулж байна. Харин ном, сонин унших, радио, FM сонсох, зурагт үзэх, компьютер, утас ашиглах, интернетэд орох зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээнд хот, хөдөөгийн ялгаа бараг байхгүй байна гэж хэлж болохоор байна (Хүйсээр нь харахад 12-22 минутын зөрөө байна).

Эрэгтэйчүүд нийт цагийнхаа 11.9 хувийг байгууллага болон хувь хүнд ажиллахад, 14.3 хувийг өрхөөрөө болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд, 1.3 хувийг үйлчилгээ, худалдаа болон бусад үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулж байхад эмэгтэйчүүд нийт цагийнхаа 10.2 хувийг байгууллага болон хувь хүнд ажиллахад, 5.6 хувийг өрхөөрөө болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд, 1.6 хувийг үйлчилгээ, худалдаа болон бусад үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулж байна.

Хөлсгүй ажил эрхлэхэд хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд 95 минут, эмэгтэйчүүд 262 минутыг зарцуулж байна. Эрэгтэйчүүд нийт цагийнхаа 4.7 хувийг өрх, гэрийн ажилд, 1.5 хувийг хүүхэд, өндөр настан, өвчтөн зэрэг өрхийн гишүүдийг асрах ажилд, 0.4 хувийг олон нийтийн болон сайн

дурын ажил, тусламжид оролцох, бусдад туслах ажилд, эмэгтэйчүүд нийт цагийнхаа 14.2 хувийг гэрийн ажилд, 3.8 хувийг хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах ажилд, 0.1 хувийг олон нийтийн болон сайн дурын ажилд оролцоход зарцуулдаг байна. Эрэгтэй, эмэгтэйчүүд олон нийтийн болон сайн дурын ажилд маш бага цаг зарцуулдаг байна.


Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд эрэгтэйчүүд 912 минут, эмэгтэйчүүд 880 минут зарцуулсан байна. Эрэгтэйчүүд нийт цагийнхаа 1.5 хувийг сурч боловсроход, 1.8 хувийг хүмүүстэй харилцах болон шашны зан үйлд, 10.0 хувийг чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд, 50.1 хувийг хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж байхад эмэгтэйчүүд нийт цагийнхаа 1.9 хувийг сурч боловсроход, 1.5 хувийг хүмүүстэй харилцах болон шашны зан үйлд, 8.2 хувийг чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд, 49.5 хувийг хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулжээ.

4.3.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг

Ажлын нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд өдрийн нийт ажлын цагийн 93.1 хувийг буюу 447 минут, эмэгтэйчүүд 66.0 хувийг буюу 317 минутыг зарцуулжээ (Зураг 4.20).


Хөлсгүй ажил эрхлэхэд эрэгтэйчүүд 91 минут буюу дунджаар 1 цаг 30 минут зарцуулсан бол эмэгтэйчүүд 251 минут буюу дунджаар 4 цаг зарцуулж байгаа нь эмэгтэйчүүд ажлын өдөр ч цалин хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд илүү олон цагийг зарцуулдаг болохыг харуулж байна.

Зураг 4.20. Хөдөлмөрийн насны хүн амын ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр



Хотын хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд ажлын нэг өдөрт нийт ажлын цагийн 82.7 хувийг, харин хөдөөгийн эрэгтэйчүүд өдрийн ажлын цагаас илүү 12 минутыг цалин хөлстэй ажилд зарцуулсан бол хотын хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд ажлын нэг өдөрт нийт ажлын 62.3 хувийг буюу 299 минут, хөдөөгийн эмэгтэйчүүд 70.6 хувийг буюу 339 минутыг тус тус зарцуулсан байна. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хотын эрэгтэйчүүд 942 минут, хөдөөгийн эрэгтэйчүүд 865 минутыг зарцуулсан нь хотын эрэгтэйчүүд хөдөөгийн эрэгтэйчүүдээс 1.2 цагийг илүү зарцуулж байна (Зураг 4.21).


Зураг 4.21. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



Хөлсгүй ажил эрхлэхэд хотын хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд 228 минут, хөдөөгийн эмэгтэйчүүд 277 минутыг зарцуулсан нь хотын эмэгтэйчүүдээс дунджаар 49 минутаар илүү зарцуулсан дүн гарчээ. Өөрийгөө хөгжүүлэх

болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн зарцуулсан цагийн хандлага эрчүүдийнхтэйгээ ижил байна.


Зураг 4.22. Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



4.3.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг


Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд амралтын өдрийн нийт цагийнхаа 24.5 хувь буюу 398 минутыг, эмэгтэйчүүд 24.0 хувь буюу 246 минутыг хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан байна. Харин амралтын өдөр хөлсгүй ажил буюу гэр орны ажил, хүүхэд, өндөр настан, өвчтэй өрхийн гишүүдийг асрахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3 цагийг илүү зарцуулжээ.

Зураг 4.23. Хөдөлмөрийн насны хүн амын амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр



Улсын дунджаар амралтын нэг өдөрт хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд 937 минут, эмэгтэйчүүд 903 минутыг зарцуулсан байна.


Зураг 4.24. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



Байгууллага болон хувь хүнд хөлстэй ажил эрхлэхэд хотын эрэгтэйчүүд амралтын нэг өдөрт 302 минут буюу 5 цаг, хөдөөгийн эрэгтэйчүүд 484 минут буюу 8 цагийг зарцуулсан байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд хотын эрэгтэйчүүдээс илүү 3 цагийг хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан нь мал аж ахуйн холбогдолтой ажил эрхэлсэнтэй холбоотой. Хөдөөгийн эрэгтэйчүүдийн нийт ажилласан цагийн 67.1 хувь буюу 325 минутыг мал аж ахуйн салбарт ажилласан дүн гарсан байна.

Амралтын нэг өдөрт хөдөлмөрийн насны хотын эрэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд 17 цагийг зарцуулсан бол хөдөөгийн эрэгтэйчүүд 3 цагаар бага хугацааг зарцуулжээ.

Зураг 4.25. Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн амралтын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр



Хотын эмэгтэйчүүд амралтын нэг өдрийн 3 цаг, хөдөөгийн эмэгтэйчүүд 5 цагийг байгууллага болон хувь хүнд цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулж байна. Хөдөөгийн эмэгтэйчүүд амралтын нэг өдрийн 317 минутыг хөлстэй ажил эрхлэх

үйл ажиллагаанд зарцуулсны 63.4 хувь буюу 201 минутыг өрхөөрөө болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулсан байна. Энэхүү үйл ажиллагааны 88.6 хувь буюу 178 минутыг мал аж ахуйн холбогдолтой үйл ажиллагаа эзэлж байна.

Хот, хөдөөгийн хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд амралтын өдрийн нийт цагийнхаа тавны нэг буюу 20.0 хувийг хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах, гэрийн ажил хийх зэрэг хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байна.

Амралтын нэг өдөрт хот, хөдөөгийн хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд ойролцоогоор 14 цагийг зарцуулсан байна.

4.4 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЦАГ АШИГЛАЛТ

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци, Монгол Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуульд 18 хүртэлх насны хүн амыг хүүхэд гэж заасан бол, НҮБ-аас гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын удирдамж, зарчмууд”-ын 3.97-д “Статистикийн зорилгоор, “хүүхэд” гэдэгт 15-аас доош насны хүн ам, “залуучууд” гэдэгт 15-24 насны хүн амыг хамааруулж ойлгоно. Гэхдээ хүн амын эдгээр тусгайлсан бүлгүүдийг 5 насны бүлгээр хуваах нь зүйтэй, учир нь энэ насны бүлгийн хүн амын сургуульд хамрагдалт, гэрлэлтийн байдал, үйл ажиллагаа гэх зэрэг шинж төрхүүд нь хурдан өөрчлөгддөг юм...” гэж заасан олон улсын нийтлэг жишиг байдаг ч энэхүү судалгааны онцлогийг харгалзан, өмнөх судалгаатай харьцуулах үүднээс 12-17 насны хүн амыг “хүүхэд”, 15-24 насны хүн амыг “залуучууд” гэж авлаа.

Цаг ашиглалтын дүр зургийг гаргахдаа судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын ҮТС-ийн болон ҮТС-ийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар тооцон гаргасан болно.

4.4.1 Хүүхдийн цаг ашиглалт

а. Ерөнхий төлөв


Аливаа улс орны хөгжил дэвшлийн суурь нь хүний хөгжил бөгөөд хүний хөгжил өөрөө хүүхдийн хөгжлөөс эхлэлтэй юм. Хүүхэд эрүүл өсч, торнин, мэдлэг, боловсрол эзэмшиж зөв төлөвших нь нийгэмд эзлэх байр суурь, хувь хүнийг тодорхойлох үндсэн хүчин зүйлүүдийн нэг билээ.

Хүүхдүүд цагаа хэрхэн өнгөрөөж байгааг судлах нь тэд хэрхэн хөгжиж байна, ирээдүйн зорилгодоо хэрхэн хүрч байна гэдгийг тодорхойлж харуулах нөхцөл болдог. Хүүхдийн цаг ашиглалтыг судалснаар тэдний хөгжил, боловсрол эзэмшихэд нөлөөлж буй нөлөөлөл, хүүхдийн нас, хүйс, хот, хөдөөгийн амьдралын орчны ялгаа, тэгш бус байдлыг харуулах ач холбогдолтой юм.

Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг


Улсын дунджаар нэг хүүхэд долоо хоногийн нэг өдөрт нийт цагийнхаа 80 гаруй хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд энд хүйсийн ялгаагүй байна. Хөлстэй хөдөлмөр эрхлэхэд хөвгүүд долоо хоногийн нэг өдөрт нийт цагийнхаа 10.9 хувь буюу 156 минут, охид 6.5 хувь буюу 93 минутыг зарцуулдаг байна (Зураг 4.26).

Зураг 4.26. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр



Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал хөвгүүдийн цалин хөлстэй ажилд зарцуулж буй цаг 1.8 пунктээр, охидынх 1.9 пунктээр тус тус нэмэгджээ. Харин цалин хөлсгүй үйл ажиллагаанд зарцуулж буй цаг хөвгүүдийнх 2.8 пунктээр, охидынх 3.3 пунктээр буурсан байна (Зураг 4.27).

Зураг 4.27. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, судалгааны дүнгээр



Хүүхдийн цаг ашиглалтанд хот, хөдөөгийн амьдралын орчны ялгаа нөлөөлдөг байна. Хотын хүүхдүүд долоо хоногийн нэг өдөрт нийт цагийнхаа 86.7-88.6 хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, 3.2-5.1 хувийг цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулдаг бол хөдөөгийн хүүхдүүд 76.8-78.0 хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, 10.5-16.7 хувийг цалин хөлстэй ажилд зарцуулдаг байна. Харин хот, хөдөөгийн хүүхдүүдийн цалин хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан цагийн хэмжээ харьцангуй ойролцоо байна. 2011 оны судалгааны дүнтэй харьцуулахад хотын хөвгүүд, охидын цалин хөлстэй ажилд зарцуулсан цаг нэмэгдсэн бол хөдөөд хөвгүүдийн энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг буурч, охидынх нэмэгджээ (Хүснэгт 4.9).

Хүснэгт 4.9. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар, судалгааны дүнгээр

	2011 он			2015 он		
	Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа
Улсын дундаж						
Эрэгтэй	131	125	1 184	156	85	1 199
Эмэгтэй	66	207	1 167	93	160	1 187
Хот						
Эрэгтэй	37	127	1 276	73	91	1 276
Эмэгтэй	33	192	1 215	47	145	1 248
Хөдөө						
Эрэгтэй	275	122	1 043	238	79	1 123
Эмэгтэй	122	233	1 085	154	180	1 106

б. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан 12-17 насны хүүхдүүд долоо хоногийн нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд өдрийн нийт цагийнхаа 3.3-6.3 хувийг байгууллага болон хувь хүнд ажил эрхлэх, 67.3-78.4 хувийг өрхөөрөө болон хувиараа анхан шатны үйлдвэрлэл, худалдаа эрхлэхэд, 14.7-21.7 хувийг ажилтай холбоотой явахад, 0.7-7.7 хувийг үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулжээ (Зураг 4.28).

Зураг 4.28. Ажлын нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар



Хөдөөгийн хүүхдүүдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулсан цагийн 85 гаруй хувийг мал аж ахуйд ажилласан цаг эзэлж байна. Хөлстэй ажил эрхлэхэд оролцсон хүүхдүүдийн цаг ашиглалтанд хүйсийн ялгаатай байдал ажиглагдаж байна. Хөвгүүдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан цаг охидынхоос илүү байна.

Хөлстэй ажил эрхлэхэд оролцсон хүүхдүүдийн цаг ашиглалтанд мөн хот, хөдөөгийн ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, хөдөөгийн эрэгтэй хүүхдийн мал аж ахуйд ажиллахад зарцуулсан цаг хотын эрэгтэй хүүхдийнхээс 13 дахин их байгаа бол хотын охидын ямар нэг байгууллага болон хувь хүнд ажил эрхлэхэд зарцуулсан цаг хөдөөгийн охидынхоос 2 дахин их байна (Хүснэгт 4.10).

Хүснэгт 4.10. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар


Үйл ажиллагаа	Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	73	47	238	154
Байгууллагад ажил эрхлэх	14	4	6	2
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	31	15	212	125
Үүнээс: Мал аж ахуй эрхлэх	14	6	182	106
Ажилтай холбоотой явах	27	23	19	17
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	2	4	0	11

в. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Хүүхдүүдийн өөрийн гэртээ хийж буй ойр зуурын гэрийн ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулдаггүй ч хүүхдүүд энэ үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тодорхой цаг зарцуулж байдаг.


Хүүхдүүд долоо хоногийн нэг өдөрт нийт цагийнхаа 5.9-11.1 хувийг хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулдаг бөгөөд энэ үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийнхаа 70-80 шахам хувь буюу дунджаар 1.0-2.0 цагийг гэрийн ажилд зарцуулдаг байна. Хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан цагт хүйсийн ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд хөвгүүд гэрийн ажил, олон нийтийн болон сайн дурын ажилд оролцох, бусдад туслахад 85 минут зарцуулдаг бол охид энэ үйл ажиллагаанд 160 минут зарцуулдаг байна. Түүнчлэн охидын хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах, зочдод үйлчлэхэд зарцуулсан цаг хөвгүүдийнхээс 1.4 дахин их байна. Эдгээр үзүүлэлтүүд нь охид хөлсгүй ажилд хөвгүүдээс илүү оролцдог болохыг харуулж байна (Зураг 4.29).

Зураг 4.29. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар



Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг хот, хөдөөгөөр ойролцоо дүнтэй байна. Тухайлбал, хотын хүүхдүүд гэрийн ажилд 60-119 минут, хөдөөгийн хүүхдүүд 58-134 минут зарцуулж байна. Харин олон нийтийн болон сайн дурын ажилд оролцох, бусдад туслахад хотын хүүхдүүд 2 минут, хөдөөгийн хүүхдүүд 6-8 минутыг зарцуулж байна (Зураг 4.30).

Зураг 4.30. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр, хүйсээр



г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Хүүхдүүд нэг өдрийн нийт цагийнхаа 80 гаруй хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг байна.

Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийнхаа 60 гаруй хувийг хооллох, ундлах, унтах гэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулжээ. Охидын хувийн хэрэгцээ болон боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан цаг хөвгүүдийнхээс илүү, хөвгүүдийн чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан цаг охидынхоос илүү байна (Зураг 4.31).


Зураг 4.31. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар



Хотын нэг хүүхэд дунджаар 21 цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг бол хөдөөгийн хүүхэд 18-19 цагийг зарцуулж байна.

Харин хотын хүүхэд хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд 13 цагийг, хөдөөгийн хүүхэд 12 цагийг зарцуулдаг байна (Зураг 4.32).


Зураг 4.32. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр



Хүүхдүүд долоо хоногийн нэг өдөрт хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд 14-44 минут зарцуулсан байгаа бөгөөд үүний дийлэнхийг ном унших, зураг зурах болон компьютер тоглоом, шатар, даам, хөзөр тоглоход зориулжээ.

Хүүхдүүдийн долоо хоногийн нэг өдөрт тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт хүйсийн ялгаа харагдаж байна. Тухайлбал, охид ном унших, зураг зурахад хөвгүүдээс илүү цаг зарцуулдаг бол хөвгүүд эсрэгээрээ компьютер тоглоом, шатар, даам, хөзөр тоглоход илүү цаг зарцуулдаг байна.


Зураг 4.33. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хувиар



Судалгаанд хамрагдсан 12-17 насны хүүхдүүдийн долоо хоногийн нэг өдөрт тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт хот, хөдөөгийн ялгаа бараг байхгүй байна. Тухайлбал, хотын хүүхдүүд компьютер тоглоом, шатар, даам, хөзөр тоглоход дунджаар 5 минут зарцуулсан бол хөдөөгийн хүүхэд 3 минут зарцуулжээ.

Хүүхдүүдийн нилээд цаг зарцуулдаг үйл ажиллагааны нэг нь боловсрол бөгөөд долоо хоногийн нэг өдөрт боловсрол сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан цаг хүүхдийн наснаас хамааран өөр өөр байна. Тухайлбал, 17 настай хүүхдүүдийн сургууль дээрх үйл ажиллагаанд зарцуулсан цаг, 15 настай хүүхдүүдийн сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг бусад хүүхдүүдийнхээс хамгийн өндөр байна.

Зураг 4.34. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар



Сургууль дээрх үйл ажиллагаанд хүүхдүүд нилээд цаг зарцуулдаг бөгөөд 13 настай хөвгүүд, 17 настай охидын энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг бусад насныхнаас илүү байна.

Чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан цаг хүүхдийн наснаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг нас ахих тусам буурч байгаа бол

соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх, спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан цаг нас харгалзахгүйгээр харьцангуй тогтвортой байна. Харин 12-15 насныхны олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээнд зарцуулсан цаг 16-17 насныхантай харьцуулахад харьцангуй их байна (Зураг 4.35).

Зураг 4.35. Долоо хоногийн нэг өдөрт хүүхдүүдийн хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар



4.4.2 Залуучуудын цаг ашиглалт

Өнөөдөр дэлхий дахинд залуучуудын нийгэмд эзлэх байр суурь оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний төлөөллийн байгууллага, залуучуудын төрийн бус байгууллага, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд анхаарч байна.

Манай улсын залуучуудын хувьд өнөөдөр тулгамдаж буй гол зорилт нь бусад хөгжиж буй

орнуудын залуучуудын нэгэн адил ажлын байртай болох, чанартай боловсрол эзэмших, нийгэмд эзлэх байр сууриа бий болгох, эцсийн дүндээ гэр бүл зохион бие даан амьдрах чадвар бүхий насанд хүрсэн хүн болох явдал юм. Иймд энэхүү судалгаагаараа залуучуудын цаг ашиглалтын мэдээллийг бий болгож, залуучуудад чиглэсэн бодлого, шийдвэрт болон судлаачдыг хэрэгцээт мэдээллээр хангахыг зорилоо.

Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг

Улсын дунджаар 15-24 насны залуучууд долоо хоногийн нэг өдрийн нийт цагийнхаа 70 гаруй хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд энд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Хөлстэй хөдөлмөр эрхлэхэд залуу эрэгтэй долоо хоногийн нэг өдрийн нийт цагийнхаа 20.4 хувь буюу 294 минут, залуу эмэгтэй 11.4 хувь буюу 164 минутыг зарцуулдаг байна (Зураг 4.36).

Зураг 4.36. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр



Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал, залуу эрэгтэйн цалин хөлстэй ажилд зарцуулж буй хугацаа 39 минутаар нэмэгдэж, залуу эмэгтэйнх 1 минутаар буурсан байна.

Залуучуудын цаг ашиглалтанд хот, хөдөөгийн амьдралын орчны ялгаа нөлөөлдөг. Хотын залуучууд долоо хоногийн нэг өдөрт нийт цагийнхаа 76.8-79.6 хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, 8.5-13.7 хувийг цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулдаг бол хөдөөгийн залуучууд нийт цагийнхаа 60 гаруй хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, 17.1-27.6 хувийг цалин хөлстэй ажилд зарцуулдаг байна. Түүнчлэн хотын залуучууд хөлсгүй ажил эрхлэхэд нийт цагийнхаа 6.7-14.7 хувийг, хөдөөгийн залуучууд 5.7-18.4 хувийг зарцуулдаг байна. Залуучуудын цалин хөлстэй ажилд зарцуулсан цагийг 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад хотын эмэгтэйчүүдийнхээс бусад нь нэмэгдсэн байна (Хүснэгт 4.11).


Хүснэгт 4.11. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар, судалгааны дүнгээр

	2011 он			2015 он		
	Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа
Улсын дундаж						
Эрэгтэй	255	112	1 073	294	89	1 057
Эмэгтэй	165	238	1 037	164	230	1 047
Хот						
Эрэгтэй	176	110	1 154	198	96	1 147
Эмэгтэй	136	206	1 098	122	212	1 106
Хөдөө						
Эрэгтэй	395	117	928	397	82	961
Эмэгтэй	228	303	909	246	264	930

Долоо хоногийн нэг өдөрт 15-24 насны залуучууд байгууллага болон хувь хүнд цалин хөлстэй ажил эрхлэхэд нийт цагийнхаа 64-92 минутыг, өрхөөр болон хувиараа анхан шатны

үйлдвэрлэл эрхлэхэд 64-159 минутыг зарцуулсан байна. Залуу эрэгтэйчүүдийн цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан цаг залуу эмэгтэйчүүдийнхээс илүү байна (Зураг 4.37).

Зураг 4.37. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр



Хотын залуучууд цалин хөлстэй ажилд зарцуулсан нийт цагийнхаа дийлэнхийг байгууллага болон хувь хүнд ажил эрхлэхэд зарцуулсан бол хөдөөгийн залуучууд анхан шатны үйлдвэрлэл эрхлэхэд дийлэнхийг нь зарцуулсан байна. Энэ нь хотынхонд байгууллага болон хувь хүнд ажиллах


боломж өөрөөр хэлбэл, ажлын байртай болох боломж илүү байдаг, хөдөөгийн залуучууд голчлон мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотой юм. Түүнчлэн хөдөөгийн залуучууд хотынхноос илүү олон цаг ажилласан байна.

Хүснэгт 4.12. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	198	122	397	246
Байгууллагад ажил эрхлэх	130	74	51	43
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	22	12	306	167
Үүнээс: Мал аж ахуй эрхлэх	9	4	271	151
Ажилтай холбоотой явах	37	29	23	18
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	9	8	17	17

Хөдөөгийн залуучууд анхан шатны үйлдвэрлэлд зарцуулсан цагийнхаа ихэнхийг мал аж ахуйд ажиллахад зарцуулжээ. Залуу эмэгтэйчүүдийн энэ цаг амралтын өдөрт нэмэгддэг бол эрэгтэйчүүдийн хувьд энэ цагт ажлын болон амралтын өдрийн ялгаа байхгүй байна.


Зураг 4.38. Долоо хоногийн, ажлын, амралтын нэг өдөрт залуучуудын мал аж ахуйн ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр



Хөлсгүй ажил эрхлэхэд залуучуудын зарцуулсан цагийн 70 гаруй хувийг өрх гэрийн ажилд зарцуулсан цаг эзэлж байна. Эрэгтэйчүүд өрх гэрийн ажилд эмэгтэйчүүдээс бага оролцдог ч хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан нийт цагийнх нь 73.9 хувийг гэрийн ажилд зарцуулсан цаг эзэлж байна.

Долоо хоногийн нэг өдөрт залуу эмэгтэйчүүдийн өрх гэрийн ажилд зарцуулсан цаг залуу эрэгтэйчүүдийнхээс 2.5 дахин, хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах, зочдод үйлчлэхэд зарцуулсан цаг 3.4 дахин илүү байна. Энэ нь өрх гэрийн ажил, хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах, зочдод үйлчлэх ажлыг эмэгтэйчүүд зонхилон хийдэгтэй холбоотой юм (Зураг 4.39).

Зураг 4.39. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр




Хөлсгүй ажил эрхлэхэд долоо хоногийн нэг өдөрт залуучуудын зарцуулсан цагт хот, хөдөөгийн амьдралын орчны ялгаатай байдал харагдаж байна. Тухайлбал, хөдөөгийн эмэгтэйчүүд болон хотын эрэгтэйчүүд өрх гэрийн ажилд 13-44 минут илүү зарцуулсан байна (Хүснэгт 4.13).

Хүснэгт 4.13. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

	Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	96	212	82	264
Өрх гэрийн ажил, нүүдэл	72	150	59	194
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	22	61	14	65
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	1	1	9	6

Долоо хоногийн нэг өдөрт 15-24 насны залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цагийн 68.8-70.4 хувийг хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг эзэлж байна. Эрэгтэйчүүдийн хүмүүстэй харилцах болон шашны зан үйл, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан цаг эмэгтэйчүүдийнхээс 0.4-3.0 минутаар илүү байна (Зураг 4.40).


Зураг 4.40. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар



Нэг өдөрт хотын залуучууд сурч боловсроход 176 минут зарцуулж байгаа бол хөдөөгийн залуучууд 77-87 минутыг зарцуулсан байна. Хот, хөдөөгийн

залуучууд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 12-13 цагийг хооллох, унтах зэрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.

Зураг 4.41. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр



Сургууль дээрх үйл ажиллагаанд 16-17 насны залуучууд хамгийн их цаг зарцуулсан бол

сургуулиас гадуурх үйл ажиллагаанд 15 болон 17 насныхан илүү их цаг зарцуулжээ.


Зураг 4.42. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар



Судалгаанд хамрагдсан 15-24 насны залуучуудын сургууль дээрх үйл ажиллагаанд нас, хүйсийн ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, 17 настай эрэгтэйчүүд, 15 настай эмэгтэйчүүд


илүү их цаг сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан бол сургууль дээрх үйл ажиллагаанд 17 настай эмэгтэйчүүд илүү их цаг зарцуулсан байна.

Зураг 4.43. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хүйсээр



Сургууль дээрх үйл ажиллагаанд хотын залуучууд хөдөөгийнхөөс илүү цаг зарцуулсан байна.


Зураг 4.44. Долоо хоногийн нэг өдөрт сургууль дээрх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хот, хөдөөгөөр



Сургуулиас гадуурх үйл ажиллагаанд хотын залуучууд хөдөөгийнхөөс илүү цаг зарцуулсан бөгөөд хотын 15 настай залуучууд, хөдөөгийн 17 настай залуучууд бусад насныхнаас илүү их цаг

зарцуулжээ. Сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг залуучуудын нас ахих тутам буурах хандлагатай байна.

Зураг 4.45. Долоо хоногийн нэг өдөрт сургуулиас гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, насаар, хот, хөдөөгөөр



Залуучуудын чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан цагийн 70-80 гаруй хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээнд ногдож байна. Нас ахих тусам чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулдаг цаг багасдаг болох нь харагдаж байна. Насны бүлэг

харгалзахгүйгээр хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа, спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулж байна.

Хүснэгт 4.14. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

	Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ
Улсын дундаж				
15-19 настай	20	16	17	132
20-24 настай	10	7	6	108
Эрэгтэй				
15-19 настай	16	18	24	144
20-24 настай	12	9	9	120
Эмэгтэй				
15-19 настай	24	14	10	121
20-24 настай	8	6	4	99
Хот				
15-19 настай	21	18	21	138
20-24 настай	13	8	9	109
Хөдөө				
15-19 настай	20	14	11	123
20-24 настай	6	5	3	108

Залуус олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад нилээд цаг зарцуулдаг бөгөөд телевиз, видео, аудио бичлэг үзэх болон интернэт ашиглахад дийлэнхи цагийг зарцуулдаг байна.

Хүснэгт 4.15. Долоо хоногийн нэг өдөрт залуучуудын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

	Телевиз, видео, аудио бичлэг үзэх	Радио, хуурцаг, "CD", "MP" сонсох	Компьютер, утас ашиглах	Интернет ашиглах
Улсын дундаж				
15-19 настай	111	1	6	15
20-24 настай	96	0	2	10
Эрэгтэй				
15-19 настай	123	1	7	12
20-24 настай	105	0	3	11
Эмэгтэй				
15-19 настай	99	1	4	17
20-24 настай	89	1	1	9
Хот				
15-19 настай	107	1	7	23
20-24 настай	90	1	2	16
Хөдөө				
15-19 настай	116	1	4	3
20-24 настай	106	0	1	1

Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг

Улсын дунджаар 15-24 насны залуучууд ажлын нэг өдөрт нийт цагийнхаа 70 гаруй хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд энд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байна. Хөлстэй хөдөлмөр эрхлэхэд залуу эрэгтэйчүүд ажлын нэг өдрийн нийт цагийнхаа 20.8 хувь буюу 299 минут, эмэгтэйчүүд 11.8 хувь буюу 170 минутыг зарцуулдаг байна. Түүнчлэн ажлын нэг өдөрт энэ насны эрэгтэйчүүд 84 минут, эмэгтэйчүүд 216 минутыг хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан нь гэрийн ажил болон өндөр настан, бага насны хүүхэд, өвчтөн асрах зэрэг ажилд эмэгтэйчүүд илүү оролцдогтой холбоотой юм.

Зураг 4.46. Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэхэд болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр




Хүснэгт 4.16. Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	209	132	397	243	299	170
Байгууллагад ажил эрхлэх	136	80	51	47	95	69
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	23	11	304	158	158	61
Үүнээс: Мал аж ахуй эрхлэх	12	5	269	143	135	51
Ажилтай холбоотой явах	40	33	25	20	33	29
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	9	8	17	18	13	11

Залуучууд ажлын нэг өдрийн нийт цагийнхаа тодорхой хэсгийг хөлсгүй ажилд зарцуулдаг бөгөөд өрх гэрийн ажилд голлон зарцуулдаг.


Залуучууд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд өдрийн нийт цагийнхаа дийлэнхийг зарцуулдаг бөгөөд хот, хөдөөгийн ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 4.47. Ажлын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот хөдөөгөөр



Хотын залуучууд ажлын нэг өдөрт хөлстэй ажилд зарцуулсан өдрийн нийт цагийнхаа 60.7-65.2 хувийг байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан бол хөдөөгийн залуучууд 58.7-67.8 хувийг өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулжээ.

Зураг 4.48. Ажлын нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр



Хөлсгүй ажилд хөдөөгийн залуучуудын зарцуулсан цагийг хотынхтой харьцуулахад 16-69 минутаар зөрүүтэй байгаа бөгөөд хүйсээр авч үзэхэд, эмэгтэйчүүдийн энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг эрэгтэйчүүдийнхээс 100-185 минутаар илүү байна.

Хүснэгт 4.17. Ажлын нэг өдөрт залуучуудын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	92	192	76	261
Өрх гэрийн ажил, нүүдэл	68	135	53	189
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	23	57	13	66
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	1	1	11	7

Ажлын нэг өдөрт 15-24 насны залуучууд өдрийн нийт цагийнхаа 73.0 хувийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд энэ үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийнхаа 14.7-16.6 хувийг сурч боловсроход зарцуулдаг байна. Хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн болон эмэгтэйчүүдийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг ижил бөгөөд хотын залуучууд хөдөөгийнхнөөс илүү цаг зарцуулжээ.


Хүснэгт 4.18. Ажлын нэг өдөрт залуучуудын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, нас, хүйс, хот, хөдөөгөөр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1 139	1 116	967	936	1 056	1 055
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	210	214	94	99	155	175
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	25	21	21	16	23	19
Чөлөөт цаг, спорт	179	141	150	127	165	136
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	725	740	701	694	714	725

Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг

Амралтын нэг өдөрт 15-24 насны эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 19.3 хувийг хөлстэй ажил эрхлэхэд, эмэгтэйчүүд 18.6 хувийг хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан байна.


Зураг 4.49. Амралтын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр



Залуучуудын цаг ашиглалтанд хот, хөдөөгийн ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, хотын залуучууд амралтын нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хөдөөгийн залуучуудаас илүү цаг зарцуулсан байна. Энэ нь хөдөөгийн залуучууд амралтын

өдөр ч цалин хөлстэй ажил, түүний дотор анхан шатны үйлдвэрлэлд хотын залуучуудаас илүү цаг зарцуулдаг учир өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг хотын залуучуудаас бага байж болох юм.

Зураг 4.50. Амралтын нэг өдөрт залуучуудын хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хот, хөдөөгөөр, хүйсээр




4.5 ӨНДӨР НАСТНЫ ЦАГ АШИГЛАЛТ

4.5.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан дундаж цаг

а. Ерөнхий төлөв

Улсын дунджаар долоо хоногийн нэг өдөрт өндөр настан буюу 60 болон түүнээс дээш настай хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг хүйсээр ялгаатай байна. Тухайлбал, өндөр настай эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт хөлстэй ажил эрхлэхэд 209 минут, хөлсгүй ажил эрхлэхэд 128 минут зарцуулсан байна. Тэгвэл долоо хоногийн нэг өдөрт өндөр настай эмэгтэйчүүд хөлсгүй ажил эрхлэхэд 264 минут, хөлстэй ажил эрхлэхэд 136 минут зарцуулсан байна.

Зураг 4.51. Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй, хөлсгүй болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр



б. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан өндөр настнууд долоо хоногийн нэг өдөрт хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийнхаа 57.7-73.7 хувийг өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх ажилд зарцуулжээ.

Зураг 4.52. Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр, хувиар



Хотын өндөр настнууд долоо хоногийн нэг өдрийн нийт цагийнхаа 1.4-2.4 хувийг байгууллагад ажил эрхлэхэд, 1.9-3.6 хувийг өрхөөр болон хувиараа анхан шатны үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулдаг байна. Хөдөөгийн өндөр настнууд өдрийн нийт цагийнхаа 10.9-19.6 хувийг өрхөөр болон хувиараа анхан шатны үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулдаг бөгөөд үүний 87 хувийг мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан байна (Зураг 4.53).


Зураг 4.53. Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, хот, хөдөөгөөр



в. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Долоо хоногийн нэг өдөрт өндөр настнуудын хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг хүйсээр ялгаатай байна. Тухайлбал, өрх гэрийн ажилд өндөр настай эмэгтэйчүүд 219-233 минут, өндөр настай эрэгтэйчүүд 82-106 минутыг зарцуулсан байна (Зураг 4.54).

Зураг 4.54. Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны цалин хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж минут, хүйсээр, хот, хөдөөгөөр




г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Ном, сонин унших, радио сонсох, телевиз үзэх зэрэгт хотын өндөр настнууд өдрийн нийт цагийн 17.2-23.2 хувийг, хөдөөгийн өндөр настнууд 13.9-16.3 хувийг зарцуулж байна.

Улсын дунджаар өндөр настнууд хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд өдрийн нийт цагийн 75.2-78.9 хувийг зарцуулсан байна (Зураг 4.55).

Зураг 4.55. Долоо хоногийн нэг өдөрт өндөр настны өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувиар, хүйсээр, хот, хөдөөгөөр



4.6 ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ ДАХ БОЛОВСРОЛЫН ЯЛГАА


4.6.1 Долоо хоногийн нэг өдөрт зарцуулсан цаг

а. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Хүн амын цаг ашиглалтанд боловсролын түвшингийн ялгаа нэлээд их байна. Тухайлбал, магистр, докторын зэрэгтэй хүмүүс хөлстэй ажил


эрхлэхэд зарцуулсан цагийнхаа 78.1 хувийг байгууллагад ажил эрхлэх, 14.6 хувийг ажилтай холбоотой явахад зарцуулсан бол боловсролгүй хүмүүс 83.5 хувийг анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд, 5.3 хувийг ажилтай холбоотой явахад зарцуулсан байна. Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам байгууллагад ажил эрхлэх нь нэмэгдэж байна (Зураг 4.56)

Зураг 4.56. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин, хувиар




Байгууллагад ажил эрхлэхэд хотын хүмүүсийн зарцуулсан хугацаа хөдөөгийнхөөс илүү байна (Зураг 4.57)

Зураг 4.57. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар



Байгууллагад ажил эрхлэхэд эмэгтэйчүүд нэг өдөрт 7-233 минут зарцуулсан бол эрэгтэйчүүд боловсролын түвшингээс хамаарч долоо хоногийн 22-300 минут зарцуулсан байна (Зураг 4.58)


Зураг 4.58. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар



Мал аж ахуй эрхлэхэд эрэгтэйчүүдийн зарцуулсан цаг эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд хүн амын боловсролын түвшин дээшлэх

утам мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан хугацаа багасч байна (Зураг 4.59).


Зураг 4.59. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар



Мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан цагт хүйсийн ялгаанаас гадна хот, хөдөөгийн амьдралын ялгаа, боловсролын түвшингийн ялгаа их байна. Боловсролгүй хүн амын энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг боловсролтой хүн амынхаас хот, хөдөөд ялгаагүй илүү байна. Хөдөөгийн хүн амын

энэ үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа хотынхоос илүү байгаа бөгөөд хүн амын боловсролын түвшин нэмэгдэх тутам мал аж ахуйд зарцуулсан хугацаа буурч байгаа нь хот, хөдөөд ялгаагүй адил ажиглагдаж байна (Зураг 4.60).

Зураг 4.60. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар



б. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Долоо хоногийн нэг өдөрт боловсролгүй хүмүүс гэрийн ажилд 142 минут зарцуулсан бол дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүмүүс 135 минут, магистр, докторын зэрэгтэй хүмүүс 113 минут

зарцуулсан байна. Боловсрол багатай хүмүүсийн гэрийн ажилд зарцуулсан хугацаа нь хот болон хөдөөд ялгаагүй байгаа бол боловсролын түвшин дээшлэх тутам хот хөдөөгийн ялгаа их болж байна (Хүснэгт 4.19).

Хүснэгт 4.19. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/доктор
Улсын дундаж								
Өрх гэрийн ажил, нүүдэл	142	139	138	158	135	162	135	113
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	27	31	41	39	31	54	47
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	3	4	5	3	3	2	2	4
Хот								
Өрх гэрийн ажил, нүүдэл	140	156	131	154	128	169	128	108
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	61	33	40	45	41	37	55	49
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	3	3	2	3	3	2	2	5
Хөдөө								
Өрх гэрийн ажил, нүүдэл	142	133	141	163	150	153	154	154
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	32	24	27	35	35	22	49	32
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	3	5	7	4	5	1	3	0

Эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулсан хугацаа нь эрэгтэйчүүдийнхээс 92-171 минутаар илүү байгаа бөгөөд хүний боловсролын түвшин нэмэгдэх тутам гэрийн ажилд зарцуулсан хугацаа багасч байна. Олон нийтийн болон сайн дурын ажилд оролцох, бусдад туслахад эрэгтэйчүүдийн

зарцуулсан цаг эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бол өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Энэ нь гэрийн ажил болон өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад боловсрол харгалзалгүй эмэгтэйчүүд голлон оролцдогтой холбоотой (Хүснэгт 4.20).

Хүснэгт 4.20. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар


	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/доктор
Улсын дундаж								
Өрх гэрийн ажил, нүүдэл	142	139	138	158	135	162	135	113
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	27	31	41	39	31	54	47
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	3	4	5	3	3	2	2	4
Эрэгтэй								
Өрх гэрийн ажил, нүүдэл	57	63	63	80	76	74	66	57
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	21	20	17	24	31	16	32	41
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	6	5	8	5	5	3	2	6
Эмэгтэй								
Өрх гэрийн ажил, нүүдэл	228	214	214	214	202	215	170	149
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	54	34	47	53	49	40	65	52
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	1	3	3	2	1	2	2	3

в. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цагт боловсролын түвшингийн ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, бага, суурь, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа

бусад боловсролын түвшинтэй хүмүүсийнхээс илүү, хүмүүстэй харилцах болон шашны зан үйл, чөлөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа боловсролын түвшин нэмэгдэх тутам нэмэгдэж байгаа бол боловсролгүй хүн амын унтах, амрах, хооллох гэх зэрэгт зарцуулсан цаг бусдаас илүү байна.

Зураг 4.61. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хувиар



Хотын хүмүүсийн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа хөдөөгийн хүмүүсийн энэ үйл ажиллагаанд зарцуулсан цагаас илүү байна (Хүснэгт 4.21).

Хүснэгт 4.21. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин								
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор	
Улсын дундаж									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	10	69	59	34	7	5	16	24	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	31	28	25	23	25	32	26	25	
Чөлөөт цаг, спорт	113	146	140	140	139	144	147	161	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	743	753	720	727	725	731	728	742	
Хот									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	21	116	105	53	7	4	15	26	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	33	31	30	24	25	32	26	26	
Чөлөөт цаг, спорт	143	193	177	146	142	158	150	160	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	847	809	767	749	736	753	743	746	
Хөдөө									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	8	49	34	7	7	5	20	10	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	31	26	22	22	25	32	27	16	
Чөлөөт цаг, спорт	107	127	120	131	132	124	136	171	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	721	729	694	696	704	698	685	706	

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа хүйсийн хувьд ялгаатай байна. Тухайлбал, боловсрол сургалтын үйл ажиллагаанд суурь боловсролоос дээш боловсролтой эрэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа

эмэгтэйчүүдийнхээс бага байгаа бол хүмүүстэй харилцах болон шашны зан үйл, чөлөөт цагийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс бага байна (Хүснэгт 4.22).

Хүснэгт 4.22. Долоо хоногийн нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар


	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Эрэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	11	70	50	29	5	1	14	19
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	31	25	24	27	27	34	30	17
Чөлөөт цаг, спорт	116	150	153	161	155	156	184	198
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	714	740	728	733	724	742	740	721
Эмэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	9	67	68	37	9	7	17	27
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	32	30	26	20	23	30	25	31
Чөлөөт цаг, спорт	110	143	127	124	121	136	128	138
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	773	766	711	722	726	723	721	755

4.6.2 Ажлын нэг өдөрт зарцуулсан цаг

а. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Ажлын нэг өдөрт хөлстэй ажилд зарцуулсан цаг боловсролын түвшин дээшлэх тутам нэмэгдэж байна (Зураг 4.62).

Зураг 4.62. Ажлын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин, хувиар



Эрэгтэйчүүдийн хөлстэй ажилд зарцуулсан цаг боловсролын түвшингээс хамаарахгүйгээр эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд боловсролын түвшин доошлох тутам өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулсан цаг нэмэгдэж байна. Харин

ажилтай холбоотой явах буюу ажилд явах болон ирэх хугацаа боловсролын түвшин дээшлэх тутам нэмэгдэж байгаа нь бага боловсролтой хүмүүс өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаатай холбоотой (Хүснэгт 4.23).

Хүснэгт 4.23. Ажлын нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Эрэгтэй								
Байгууллагад ажил эрхлэх	41	22	77	201	252	203	302	374
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	397	315	278	128	106	169	31	20
Ажилтай холбоотой явах	26	21	28	44	45	35	56	64
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	9	7	17	22	22	20	17	2
Эмэгтэй								
Байгууллагад ажил эрхлэх	7	17	51	132	195	170	274	265
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	199	142	157	84	71	68	22	10
Ажилтай холбоотой явах	15	15	21	31	38	29	45	49
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	21	17	18	29	22	33	15	10

Хотын хүмүүс байгууллагад ажил эрхлэхэд илүү цаг зарцуулсан бол хөдөөгийн хүмүүс өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх, түүний дотор мал аж ахуй эрхлэхэд илүү


цаг зарцуулсан байна. Энэ нь хотынхонд ажлын байртай болох, ажил олох боломж хөдөөгийнхнөөс илүү байдаг, хөдөөгийн хүмүүс гол төлөв мал аж ахуй эрхэлдэг зэрэгтэй холбоотой (Хүснэгт 4.24).

Хүснэгт 4.24. Ажлын нэг өдөрт хүн амын байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Улсын дундаж								
Байгууллагад ажил эрхлэх	25	19	64	161	225	182	283	307
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	302	228	218	103	90	106	25	14
Ажилтай холбоотой явах	21	18	25	36	42	31	49	55
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	15	12	17	26	22	28	16	7
Хот								
Байгууллагад ажил эрхлэх	72	28	100	194	284	223	299	317
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	84	46	47	24	24	30	6	6
Ажилтай холбоотой явах	32	21	31	42	48	36	53	57
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	9	10	16	22	21	19	11	7
Хөдөө								
Байгууллагад ажил эрхлэх	14	16	45	114	108	124	242	232
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	349	304	312	212	220	214	75	81
Ажилтай холбоотой явах	19	17	21	27	28	24	37	38
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	16	13	18	32	25	42	28	4

Ажлын нэг өдөрт эрэгтэйчүүдийн мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан хугацаа багасч байна.

Зураг 4.63. Ажлын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар



Мал аж ахуйд ажиллахад зарцуулсан цаг хүйсийн ялгаанаас гадна хот, хөдөөгийн, боловсролын түвшний ялгаа их байна. Боловсролгүй хүн амын энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг боловсролтой хүн амынхаас хот,

хөдөөд ялгаагүй илүү байна. Хөдөөгийн хүн амын энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг хотынхоос илүү байгаа бөгөөд хүн амын боловсролын түвшин нэмэгдэх тутам зарцуулсан цаг буурч байгаа нь хот, хөдөөд ялгаагүй ажиглагдаж байна.

Зураг 4.64. Ажлын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар



б. Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа

Ажлын нэг өдөрт боловсролгүй, бага боловсролтой хүмүүс гэрийн ажилд 136-140 минут зарцуулсан бол дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүмүүс 120 минут, магистр, докторын

зэрэгтэй хүмүүс 97 минут зарцуулсан байна. Хотын боловсролгүй хүмүүсийн гэрийн ажилд зарцуулсан хугацаа улсын дунджаас 5 минут, хөдөөгийнхөөс 6 минутаар бага байна (Хүснэгт 4.25).

Хүснэгт 4.25. Ажлын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Улсын дундаж								
Өрх гэрийн ажил, нүүдэл	140	136	133	153	129	154	120	97
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	27	31	42	40	32	53	47
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	4	6	3	3	2	2	3
Хот								
Өрх гэрийн ажил, нүүдэл	135	147	122	145	119	155	112	90
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	63	34	39	45	42	38	55	48
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	3	2	3	2	2	2	4
Хөдөө								
Өрх гэрийн ажил, нүүдэл	141	131	139	163	148	153	143	155
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	32	23	27	37	35	22	50	36
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	4	8	2	4	2	4	-

Ажлын нэг өдөрт эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулсан цаг эрэгтэйчүүдийнхээс 88-174 минутаар илүү байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх тутам гэрийн ажилд зарцуулсан хугацаа багасч байна.

Олон нийтийн болон сайн дурын ажилд оролцох, бусдад туслахад эрэгтэйчүүдийн

зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бол өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Энэ нь гэрийн ажил болон хүүхэд, өндөр настан, өвчтөн асрахад нас, боловсрол харгалзахгүй эмэгтэйчүүд голлон оролцдогтой холбоотой (Хүснэгт 4.26).

Хүснэгт 4.26. Ажлын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар

	Боловсролын түвшин								
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор	
Эрэгтэй									
Өрх гэрийн ажил, нүүдэл	56	61	60	77	74	70	60	43	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	18	20	16	24	31	16	31	37	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	7	5	9	4	4	2	3	8	
Эмэгтэй									
Өрх гэрийн ажил, нүүдэл	230	211	207	206	192	204	150	131	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	58	33	47	54	50	41	65	53	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	1	3	3	2	1	2	2	1	

в. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Ажлын нэг өдөрт бага, суурь, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа бусад түвшний боловсролтой хүмүүсийнхээс илүү, чөлөөт цаг,

спортын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа боловсролын түвшин дээшлэх тутам нэмэгдэж байгаа бол боловсролгүй болон бага боловсролтой хүн амын унтах, амрах, хооллох зэрэг хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа нь бусад түвшний боловсролтой хүмүүсээс илүү байна (Хүснэгт 4.27).

Хүснэгт 4.27. Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин								
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор	
Улсын дундаж									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	13	82	72	40	8	6	18	23	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	32	26	25	22	26	31	25	26	
Чөлөөт цаг, спорт	114	142	136	136	134	143	135	141	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	739	747	713	721	721	726	713	720	
Хот									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	28	141	130	63	8	5	17	25	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	30	29	29	21	26	29	24	27	
Чөлөөт цаг, спорт	137	184	171	141	136	155	137	139	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	845	797	753	739	729	749	725	721	
Хөдөө									
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	9	57	41	7	9	6	21	12	
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	32	25	22	22	26	34	28	18	
Чөлөөт цаг, спорт	108	124	117	130	131	125	131	154	
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	716	726	691	694	705	693	681	711	

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа хүйсийн хувьд ялгаатай байна. Тухайлбал, боловсрол сургалтын үйл ажиллагаанд суурь боловсролоос дээш боловсролтой эрэгтэйчүүдийн зарцуулсан

хугацаа эмэгтэйчүүдийнхээс бага байгаа бол чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс бага байна (Хүснэгт 4.28).

Хүснэгт 4.28. Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Эрэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	14	84	62	35	6	2	17	20
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	33	25	24	24	30	33	28	20
Чөлөөт цаг, спорт	121	148	148	156	150	152	165	162
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	717	734	722	725	721	738	729	692
Эмэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	11	80	83	43	10	8	18	25
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	30	28	25	20	23	30	23	30
Чөлөөт цаг, спорт	105	136	125	122	116	137	120	127
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	763	759	704	717	722	719	705	738

4.6.3 Амралтын нэг өдөрт зарцуулсан цаг

а. Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа

Амралтын нэг өдөрт хөлстэй ажилд зарцуулсан хугацаа долоо хоногийн нэг өдөр болон ажлын нэг өдөрт зарцуулсан цагаас бага байгаа ч мөн л боловсролын ялгаа ажиглагдаж байна. Хотын

боловсролгүй хүмүүсийн байгууллагад ажил эрхлэхэд зарцуулсан хугацаа нь хөдөөгийн боловсролгүй хүмүүсийнхээс 10.3 дахин их байгаа бол хөдөөгийн хүмүүсийн мал аж ахуйд зарцуулсан хугацаа хотынхоос 14 дахин их байна (Хүснэгт 4.29).

Хүснэгт 4.29. Амралтын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Улсын дундаж								
Байгууллагад ажил эрхлэх	29	16	51	127	178	129	138	83
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	298	222	226	111	96	116	36	19
Ажилтай холбоотой явах	19	14	20	27	35	23	32	23
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	10	15	17	22	23	33	20	12
Хот								
Байгууллагад ажил эрхлэх	113	13	82	152	216	140	134	80
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	30	44	51	23	31	29	10	0
Ажилтай холбоотой явах	27	14	21	32	41	27	35	22
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	12	16	16	17	23	32	15	14
Хөдөө								
Байгууллагад ажил эрхлэх	11	17	35	91	97	113	148	118
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	355	299	320	233	237	239	111	188
Ажилтай холбоотой явах	17	14	20	21	23	19	23	32
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	9	15	17	28	23	36	36	0

Амралтын нэг өдөрт эрэгтэйчүүдийн хөлстэй ажилд зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд энэ хандлага боловсролын түвшингээр ялгаагүй байна (Хүснэгт 4.30).

Хүснэгт 4.30. Амралтын нэг өдөрт хүн амын хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Эрэгтэй								
Байгууллагад ажил эрхлэх	54	22	67	158	226	145	165	77
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	433	324	283	140	105	188	49	42
Ажилтай холбоотой явах	25	18	25	31	43	25	45	31
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	4	9	12	17	20	25	22	4
Эмэгтэй								
Байгууллагад ажил эрхлэх	6	10	35	104	126	119	124	88
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	178	126	168	89	87	71	29	4
Ажилтай холбоотой явах	14	10	16	25	26	22	26	19
Үйлчилгээ болон бусад үйлдвэрлэл эрхлэх	15	21	21	25	27	39	19	18

Эрэгтэйчүүдийн мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс илүү байна. Мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан хугацаа боловсролын түвшин дээшлэх тутам багасч байна (Хүснэгт 4.31).

Хүснэгт 4.31. Амралтын нэг өдөрт хүн амын мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйс, хот хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин								
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор	
Хүйс									
Эрэгтэй	416	289	244	109	78	130	36	39	
Эмэгтэй	160	110	143	75	72	52	19	1	
Суурьшил									
Хот	24	24	32	12	16	15	4	0	
Хөдөө	335	271	282	199	202	176	87	160	

б. Хөлсгүй ажил эрхлэхэд үйл ажиллагаа

Амралтын нэг өдөрт боловсролгүй, бага боловсролтой хүмүүс гэрийн ажилд 146-148 минут зарцуулсан бол дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүмүүс 174 минут, магистр, докторын зэрэгтэй хүмүүс 164 минут зарцуулсан байна.

Амралтын нэг өдөрт хүн амын энэ үйл ажиллагаанд зарцуулсан цаг ажлын нэг өдөрт зарцуулсан цагаас нэмэгдсэн байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин нэмэгдэх тутам илүү ихээр ажиглагдаж байна (Хүснэгт 4.32).

Хүснэгт 4.32. Амралтын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин								
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор	
Улсын дундаж									
Өрх гэрийн ажил, нүүдэл	146	148	151	171	152	183	174	164	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	28	32	39	38	29	55	49	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	2	5	5	5	5	2	1	6	
Хот									
Өрх гэрийн ажил, нүүдэл	151	177	156	176	149	204	171	165	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	55	31	42	47	38	35	58	53	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	0	2	1	3	5	4	1	7	
Хөдөө									
Өрх гэрийн ажил, нүүдэл	145	136	148	165	157	154	184	152	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	33	26	26	29	36	20	48	16	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	2	6	7	8	5	0	1	0	

Амралтын нэг өдөрт эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс 105-221 минутаар илүү байгаа бөгөөд ажлын нэг өдөрт зарцуулсан хугацаанаас илүү байна.

Олон нийтийн болон сайн дурын ажилд оролцох, бусдад туслахад эрэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа

эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бол өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Амралтын нэг өдөрт эдгээр үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа ажлын өдрийнхөөс илүү байна (Хүснэгт 4.33).

Хүснэгт 4.33. Амралтын нэг өдөрт хүн амын хөлсгүй ажил эрхлэхэд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар


	Боловсролын түвшин								
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/Доктор	
Эрэгтэй									
Өрх гэрийн ажил, нүүдэл	3	69	72	88	81	84	82	101	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	27	21	18	22	31	16	35	52	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	2	5	6	7	9	4	1	0	
Эмэгтэй									
Өрх гэрийн ажил, нүүдэл	224	222	232	233	229	245	222	206	
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	46	34	46	52	45	37	66	48	
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	1	4	3	3	1	1	1	11	

в. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Амралтын нэг өдөрт бага, суурь, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа бусад түвшний

боловсролтой хүмүүсийнхээс илүү, хүмүүстэй харилцах болон шашны зан үйл, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа боловсролын түвшин дээшлэх тутам нэмэгдэж байна (Зураг 4.65).

Зураг 4.65. Амралтын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, минутаар



Амралтын нэг өдөрт хүмүүстэй харилцах болон шашны зан үйлд зарцуулсан хугацаа хот, хөдөөд ойролцоо байгаа бөгөөд 2-15 минутын ялгаатай байна (Хүснэгт 4.34).

Хүснэгт 4.34. Амралтын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Хот								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	53	40	25	5	3	10	29
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	38	34	33	29	23	38	32	25
Чөлөөт цаг, спорт	158	215	194	161	157	164	186	223
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	853	841	804	775	752	764	788	822
Хөдөө								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	27	17	6	3	2	20	0
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	29	30	22	24	21	26	21	10
Чөлөөт цаг, спорт	103	134	127	134	136	122	149	232
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	731	739	702	700	700	710	698	692

Амралтын нэг өдөрт өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа хүйсийн хувьд ялгаатай байна. Тухайлбал, боловсрол сургалтын үйл ажиллагаанд суурь боловсролоос дээш боловсролтой эрэгтэйчүүдийн

зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс бага байгаа бол чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн зарцуулсан хугацаа эрэгтэйчүүдийнхээс бага байна (Хүснэгт 4.35).

Хүснэгт 4.35. Ажлын нэг өдөрт хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйсээр, минутаар

	Боловсролын түвшин							
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр/ Доктор
Эрэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	34	20	14	3	0	8	16
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	25	28	25	33	22	36	34	9
Чөлөөт цаг, спорт	103	157	166	176	167	164	232	306
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	705	754	746	753	734	753	768	806
Эмэгтэй								
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	36	30	19	7	4	15	33
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	35	34	27	23	23	32	28	33
Чөлөөт цаг, спорт	122	160	134	130	132	135	147	170
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	794	784	729	737	738	735	763	811



**ТАВДУГААР БҮЛЭГ
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**



5.1 ДҮГНЭЛТ


- Хүн амын өсөлт, улс орны нийгэм, эдийн засгийн байдал нь хүн амын цаг ашиглалтанд нөлөөлж байна.** Судалгааны дүнгээс харахад цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан цаг өмнөх судалгааны үр дүнгээс өссөн байна. Тухайлбал, хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт хөлстэй хөдөлмөрт 7 цаг, эмэгтэйчүүд 5 цагийг зарцуулж байгаа нь 2011 оны судалгааны үеэс тус бүр 1 цагаар нэмэгдсэн байна. Харин өдрийн нийт цагт хүүхдүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан хугацаа нэг пунктээр нэмэгдсэн бол залуучуудынх нэг пунктээр буурсан дүн харагдаж байна. Энэ нь нэг талаас сүүлийн жилүүдэд манай улсын хувьд Хүн амын цонхны үе буюу нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь өндөр байгаатай, нөгөө талаас хөдөлмөрийн зах зээл дээрх ажил, ажлын хэлбэр маш хурдацтай шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаатай, ажиллагчдын давхар хөдөлмөр эрхлэлт, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх хандлагатай байгаатай холбоотой гэж үзэж байна.
 - Хүн амын цаг ашиглалтанд хүн амын насны бүтэц нөлөөлж байна.** Улсын дунджаар хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа гуравны нэгийг, эмэгтэйчүүд тавны нэгийг хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байна. Хүүхдүүд хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд өдрийн нийт цагийнхаа 5.9-11.1 хувийг, залуучууд 6.1-16.0 хувийг зарцуулдаг байна.
 - Цаг ашиглалтанд хүйсийн ялгаа байна.** Эрэгтэйчүүд цалин хөлстэй ажилд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулсан ч эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй ажилд зарцуулсан цаг эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд насны ялгаа бараг байхгүй байна. Гэрийн ажил, хүүхэд, өндөр настан болон өвчтэй хүн асрах ажилд эмэгтэйчүүд голлон оролцдог оос тэдний цалин хөлстэй ажилд зарцуулах цаг эрэгтэйчүүдийнхээс бага байж болох юм. Жишээлбэл, хөлстэй ажил эрхлэхэд долоо хоногийн нэг өдөрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 цагаар, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3 цагаар
- илүү цагийг зарцуулсан байна. Гэрийн ажилд эмэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 14.2 хувь буюу 205 минутыг, эрэгтэйчүүд ердөө 4.7 хувь буюу 67 минутыг л зарцуулж байна.
- Хүн амын цаг ашиглалтанд хот, хөдөөгийн амьдралын ялгаа нөлөөлж байна.** Хотын хүмүүс албан байгууллага болон хувь хүнд цалин хөлстэй ажил эрхлэх боломж илүү байгаа бол хөдөөгийн хүмүүс гол төлөв өрхөөрөө болон анхан шатны боловсруулах үйлдвэрлэл буюу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Түүнчлэн хөдөөгийн хүмүүс сурч боловсрох болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд маш бага цаг, харин олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ, хүмүүстэй харилцах болон шашны зан үйлийн цагийн зарцуулалт нь хот суурин газрын хүмүүстэй ойролцоо байна. Хөдөөгийн насанд хүрсэн болон хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд хотын насанд хүрсэн эрэгтэйчүүдээс хөлстэй хөдөлмөрт 2 цагаар илүү хугацааг зарцуулсан нь хөдөөд хүмүүс ихэвчлэн цагийн хязгаарлалтгүй ажил буюу мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотой юм. Түүнчлэн хотын залуучууд долоо хоногийн нэг өдөрт сурч боловсрох үйл ажиллагаанд 176 минут зарцуулсан бол хөдөөгийн залуучуудынх 77-87 минут байна.
 - Хүн амын цаг ашиглалтанд боловсролын түвшний ялгаа ажиглагдаж байна.** Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам цалин хөлстэй ажил эрхлэх, түүний дотор байгууллага болон хувь хүнд ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж буй цаг нэмэгдэж байна. Бага боловсролтой болон боловсролгүй хүмүүс нэг өдөрт цалин хөлстэй ажил эрхэлсэн цагийнхаа дийлэнхийг өрхөөрөө болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл, түүний дотор мал аж ахуй эрхлэхэд зарцуулсан байна. Хүн амын цаг ашиглалтанд боловсролын түвшний ялгаа нилээд их байна. Тухайлбал, магистр, докторын зэрэгтэй хүмүүс хөлстэй ажил эрхлэхэд зарцуулсан цагийнхаа 78.1 хувийг байгууллага болон хувь хүнд ажил эрхлэхэд зарцуулсан бол боловсролгүй хүмүүс 83.5 хувийг өрхөөрөө болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд зарцуулсны 78.3 хувь нь мал аж ахуй эрхлэхэд зарцуулжээ.

- Сүүлийн жилүүдэд мэдээлэл технологийн үйлчилгээний хамрах хүрээ нэмэгдэж, шинэ техник технологи, үйлчилгээ нэвтэрч, үүрэн утас болон интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын үзүүлж буй үйлчилгээний төрөл нэмэгдэж, үнийн таатай нөхцөл бий болсноор хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн нь хүн амын цаг ашиглалтанд нөлөөлжээ. Чөлөөт цаг, спортын үйл ажиллагааны 80-аас дээш хувийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ эзэлж байгаа бөгөөд энэхүү хэрэглээ нь хүйсээр ялгаатай харагдаж байна. Эрэгтэйчүүд ном, сонин унших, радио сонсох, телевиз үзэх, компьютер, утас ашиглах, интернэтэд орох зэрэг ажилд өдрийн нийт цагийнхаа 9.0 хувь буюу 130 минутыг зарцуулдаг бол эмэгтэйчүүд 7.4 хувь буюу 107 минутыг зарцуулж байна. Харин хүүхэд, залуучууд энэ үйл ажиллагаанд өдөрт 2-оос дээш цагийг зарцуулж байна.
- **Эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотойгоор явах замд зарцуулсан хугацаа хот, хөдөө, хүйсээр ялгаатай байна.** Өдөрт Үндэсний тооцооны системийн хүрээний үйл ажиллагаа буюу хөлстэй ажил эрхлэхтэй холбоотойгоор ажилдаа ирж очих замд хот, суурин газарт 39-48 минут, хөдөө орон нутагт 20-28 минутыг зарцуулж байна. Харин суралцахтай холбоотойгоор хүүхдүүд хот, суурин газарт 31 минут, хөдөө орон нутагт 27-30 минутыг ирж очих замд зарцуулжээ.

5.2 ЗӨВЛӨМЖ

- Хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхээр байгаа тул хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг олноор бий болгох;
- Төвлөрлийг сааруулж, хөдөөгийн эдийн засгийн хөгжил төдийгүй хүний хөгжилд анхаарч, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад тулгуурласан ялгаатай бодлогыг хэрэгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах;
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын чанарыг сайжруулж, чадвартай ажиллах хүчин бэлтгэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Залуучуудад суралцахын зэрэгцээ хөдөлмөр эрхлэх боломж олгох, мэргэших, хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнесээ өргөжүүлж, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Залуучуудыг нэг ажлын байранд тогтвортой урт хугацаанд ажиллаж амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор олон ажлуудыг санаачлан зохион байгуулах;
- Хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, секц, дугуйланг олшруулах, тэдэнд зориулан чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх аюулгүй нөхцөлийг нь хангасан газруудыг бий болгох, цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлэх.

----- 000 -----



**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ХАВСРАЛТ**



Хүнснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүн амын насны бүтэц, хүйсээр

Үзүүлэлтүүд	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	6 610	100.0	7 016	100.0	13 626	100.0
0 - 4	841	12.7	811	11.6	1 652	12.1
5 - 9	670	10.1	720	10.3	1 390	10.2
10 - 14	539	8.1	608	8.7	1 147	8.4
15 - 19	554	8.4	515	7.3	1 069	7.8
20 - 24	536	8.1	505	7.2	1 041	7.6
25 - 29	546	8.3	570	8.1	1 116	8.2
30 - 34	552	8.4	579	8.3	1 131	8.3
35 - 39	521	7.9	537	7.7	1 058	7.8
40 - 44	465	7.0	464	6.6	929	6.8
45 - 49	379	5.7	412	5.9	791	5.8
50 - 54	367	5.6	417	5.9	784	5.8
55 - 59	231	3.5	298	4.2	529	3.9
60 - 64	151	2.3	211	3.0	362	2.7
65 - 69	97	1.5	136	1.9	233	1.7
70 +	161	2.4	233	3.3	394	2.9
Хүүхэд (0-11)	1 743	26.4	1 792	25.5	3 535	25.9
Өсвөр насныхан(12-17)	642	9.7	659	9.4	1 301	9.6
Насанд хүрэгчид (18+)	4 225	63.9	4 565	65.1	8 790	64.5

Хүнснэгт 2. Судалгаанд хамрагдсан өрхийн бүтэц, сонгосон үзүүлэлтээр

Бүгд	3 990	100.0
Суурьшил		
Хот	2 068	51.8
Хөдөө	1 922	48.2
Байршил		
Нийслэл	1 200	30.4
Аймгийн төв	868	21.4
Сумын төв	969	24.3
Хөдөө	953	23.9
Бүс		
Баруун	638	16.0
Хангай	799	20.0
Төв	797	20.0
Зүүн	556	13.9
Улаанбаатар	1 200	30.1
Өрхийн тэргүүлэгчийн хүйс		
Эрэгтэй	3 102	77.7
Эмэгтэй	888	22.3
Өрхийн ам бүлийн тоо		
1	1 465	14.7
2-3	1 545	36.7
4-5	332	38.7
6-7	53	8.3
8-9	9	1.3
10+	3 990	0.3

Хүнснэгт 3. Судалгаанд хамрагдсан өрх, сууцны төрлөөр, сонгосон үзүүлэлтээр, хувиар

Үзүүлэлт	Сууцны төрөл, %							Дүн	Өрхийн тоо
	Үүнээс:								
	Гэр	Зориулалтын бусад сууц	Байшин	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн зориулалтын байр		
Бүгд	47.9	0.4	51.7	20.4	1.1	28.2	2.0	100.0	3 990
Өрхийн тэргүүлэгчийн хүйс									
Эрэгтэй	49.1	0.4	50.5	19.3	1.3	28.1	1.8	100.0	3 102
Эмэгтэй	43.5	0.7	55.8	23.9	0.6	28.8	2.5	100.0	888
Суурьшил									
Хот	30.8	0.5	68.7	34.4	1.9	30.3	2.1	100.0	2 068
Хөдөө	66.3	0.2	33.5	5.3	0.3	26.1	1.8	100.0	1 922
Байршил									
Нийслэл	24.7	0.5	74.8	44.4	0.7	27.4	2.3	100.0	1 213
Аймгийн төв	39.3	0.7	60	20.2	3.6	34.4	1.8	100.0	855
Сумын төв	42.6	0.3	57.1	10.4	0.6	43.2	2.9	100.0	969
Хөдөө	90.5	0.2	9.3	-	-	8.6	0.7	100.0	953
Бүс									
Баруун	66.5	0.3	33.2	5.8	2.5	23.5	1.4	100.0	638
Хангай	78.8	-	21.2	5.4	1.4	14.0	0.4	100.0	799
Төв	35.7	0.3	64	17.7	1.1	43.8	1.4	100.0	797
Зүүн	49.4	1.3	49.3	10.4	0.2	33.8	4.9	100.0	556
Улаанбаатар	24.7	0.6	74.7	44.4	0.7	27.3	2.3	100	1200

Хүнснэгт 4. Судалгаанд хамрагдсан өрх, хөрөнгийн эзэмшлээр, сонгосон үзүүлэлтээр, хувиар

Үзүүлэлт	Суудлын машинтай өрх	Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрх	Малтай өрх	Малын тоогоор						Өрхийн тоо
				100 хүртэлх	101-200	201-300	301-400	401-500	501-ээс дээш	
Бүгд	32.1	6.6	36.7	39.4	18.3	14.0	7.8	5.5	15.0	3 990
Өрхийн тэргүүлэгчийн хүйс										
Эрэгтэй	89.7	81.5	86.3	37.0	17.9	14.6	8.0	6.0	16.5	3 102
Эмэгтэй	10.3	18.5	13.7	54.2	21.4	9.9	7.0	2.0	5.5	888
Суурьшил										
Хот	63.6	35.1	11.8	64.2	18.5	8.1	2.9	1.7	4.6	2 068
Хөдөө	36.4	64.9	88.2	36.0	18.3	14.8	8.5	6.0	16.4	1 922
Байршил										
Нийслэл	43.9	2.5	4.5	74.1	74.1	11.1	5.6	3.7	3.7	1 213
Аймгийн төв	33.1	7.4	13.9	60.7	59.7	21.8	1.7	0.8	5.0	855
Сумын төв	27.8	14.9	43.8	64.9	63.7	16.3	2.4	2.4	5.2	969
Хөдөө	20.7	2.9	91.2	22.6	22.6	19.3	11.5	7.7	21.9	953
Бүс										
Баруун	27.3	5.2	57.4	39.6	39.6	19.7	7.9	5.5	15.8	638
Хангай	26.8	2.1	61.7	31.6	31.6	21.9	8.7	6.5	12.0	799
Төв	33.4	15.2	40.2	46.4	43.8	10.9	9.4	2.8	19.7	797
Зүүн	17.8	11.7	43.0	42.3	41.8	20.1	4.6	7.1	16.3	556
Улаанбаатар	44.0	2.4	4.0	75.0	75.0	12.5	4.2	4.2	2.1	1 200

Хүнснэгт 5. Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшин, сонгосон үзүүлэлтээр, хувиар

Үзүүлэлт	Боловсролын түвшин								Дүн	Хүний тоо
	Боловсрол-гүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор		
Бүгд	4.9	13.7	21.8	27.0	8.6	5.0	17.8	1.2	100.0	10 091
Хүйс										
Эрэгтэй	5.4	14.6	23.8	26.4	10.4	4.1	14.2	1.1	100.0	4 867
Эмэгтэй	4.4	12.9	19.9	27.6	7.0	5.7	21.2	1.3	100.0	5 224
Суурьшил										
Хот	2.3	8.4	14.8	30.0	11.0	5.6	25.8	2.1	100.0	5 170
Хөдөө	7.7	19.3	29.1	23.8	6.1	4.3	9.4	0.3	100.0	4 921
Байршил										
Нийслэл	1.4	6.8	11.9	27.9	12.8	5.5	30.7	3.0	100.0	2 945
Аймгийн төв	3.4	10.5	18.7	32.9	8.6	5.7	19.4	0.8	100.0	2 225
Сумын төв	4.4	14.0	24.0	28.5	7.3	6.0	15.4	0.4	100.0	2 413
Хөдөө	10.9	24.4	34.1	19.2	5.0	2.6	3.7	0.1	100.0	2 508
Бүс										
Баруун	7.6	17.6	24.1	27.8	3.8	4.6	13.9	0.6	100.0	1 761
Хангай	6.1	24.4	30.7	22.1	4.5	2.6	9.2	0.4	100.0	1 966
Төв	5.1	10.3	24.1	28.4	9.0	6.6	16.0	0.5	100.0	2 021
Зүүн	6.9	13.5	24.0	28.9	11.2	4.9	10.5	0.1	100.0	1 398
Улаанбаатар	1.4	6.8	11.9	27.9	12.8	5.5	30.7	3.0	100.0	2 945

Хүнснэгт 6. Судалгаанд хамрагдсан хүн амын гэрлэлтийн байдал, сонгосон үзүүлэлтээр, хувиар

Үзүүлэлт	Гэрлэлтийн байдал						Дүн	Хүний тоо
	Огт гэрлээгүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн		
Бүгд	27.5	55.3	5.7	1.5	1.9	8.1	100.0	9 437
Суурьшил								
Хот	26.4	53.6	6.4	2.0	2.5	9.1	100.0	4 895
Хөдөө	28.9	57.0	5.0	0.9	1.3	6.9	100.0	4 542
Байршил								
Нийслэл	25.0	53.3	7.1	2.3	2.9	9.4	100.0	2 804
Аймгийн төв	28.2	54.1	5.3	1.5	2.0	8.9	100.0	2 058
Сумын төв	26.3	56.6	6.5	1.0	1.6	8.0	100.0	2 233
Хөдөө	31.4	57.5	3.5	0.8	1.0	5.8	100.0	2 309
Хүйс								
Эрэгтэй	31.6	57.0	5.4	1.3	1.6	3.1	100.0	4 560
Эмэгтэй	23.8	53.7	6.0	1.6	2.2	12.7	100.0	4 877
Бүс								
Баруун	31.6	57.4	1.8	0.5	1.2	7.5	100.0	1 619
Хангайн	29.4	58.7	2.2	0.8	0.7	8.2	100.0	1 825
Төвийн	26.8	54.3	8.5	1.4	2.1	6.9	100.0	1 878
Зүүн	26.6	53.6	8.5	1.8	2.0	7.5	100.0	1 311
Улаанбаатар	25.0	53.3	7.1	2.3	2.9	9.4	100.0	2 804

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, байршил, хүйсээр

Үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин
Улсын дүн	61.7	11.6	50.4	9.3	55.9	10.6
Суурьшил						
Хот	56.7	12.1	42.9	9.0	49.3	10.6
Хөдөө	66.7	11.3	59.2	9.6	63.0	10.5
Байршил						
Нийслэл	62.1	5.9	42.4	5.3	51.4	5.6
Аймгийн төв	49.5	20.6	43.6	13.5	46.4	17.2
Сумын төв	53.7	20.0	46.2	16.7	49.9	18.5
Хөдөө	78.5	4.8	72.5	4.3	75.7	4.6

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан 15, түүнээс дээш насны ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хот, хөдөөгөөр, хувиар

Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Хот		Хөдөө		Улсын дүн		Ажиллагчид
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	5 273
Цалин хөлстэй ажиллагч	69.2	74.2	26.5	30	45.8	50.4	2 529
Ажил олгогч	2.4	1.3	0.5	0.6	1.4	0.9	61
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	23.4	19.5	13.6	10.1	18.0	14.5	864
Нөхөрлөл, хоршооны гишүүн	0.3	0.3	0.1	0.1	0.2	0.2	10
Мал аж ахуй эрхлэгч	4.2	3.5	59.1	58.4	34.3	33.1	1 777
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч"	0.4	1.1	0.2	0.8	0.3	0.9	30
Бусад	0.1	0.1	0	0	0	0	2

Хүснэгт 9. 7 хоногийн нэг өдөрт хүн амын насны бүлгүүдийн цаг ашиглалт, хот, хөдөө, хүйсээр, минутаар

Хүн амын насны бүлгүүд	Хот		Хөдөө		Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа							
Насанд хүрэгчид		349	249	480	323	417	283
Хөдөлмөрийн насны хүн ам		371	267	489	333	433	298
Хүүхдүүд		74	47	238	154	156	93
Залуучууд		198	122	397	246	294	164
Өндөр настан		116	88	326	208	209	135
Нийт хүн ам (12 ба түүнээс дээш насны)		320	230	457	308	391	266
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа							
Насанд хүрэгчид		113	253	86	279	99	265
Хөдөлмөрийн насны хүн ам		107	246	85	280	95	262
Хүүхдүүд		91	145	79	180	85	160
Залуучууд		95	212	82	264	89	230
Өндөр настан		149	275	101	248	128	264
Нийт хүн ам (12 ба түүнээс дээш насны)		111	243	85	271	97	256
ҮТС-ийн бус үйл ажиллагаа							
Насанд хүрэгчид		978	938	874	838	924	892
Хөдөлмөрийн насны хүн ам		962	927	866	827	912	880
Хүүхдүүд		1 275	1 248	1 123	1 106	1 199	1 187
Залуучууд		1 147	1 106	961	930	1 057	1 046
Өндөр настан		1 175	1 077	1 013	984	1 103	1 041
Нийт хүн ам (12 ба түүнээс дээш насны)		1 009	967	898	861	952	918

Хүснэгт 10. 7 хоногийн нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөө, хүйсээр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 440	1 440	1 440	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	320	230	457	308	391	266
Байгууллагад ажил эрхлэх	222	161	74	77	146	123
Өрхөөр болон хувиараа анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэх (ХАА ороод)	37	18	340	184	194	94
Үүнээс:						
Мал аж ахуй	23	10	300	164	166	80
Өрхөөр болон хувиараа анхан шатны бус боловсруулах үйлдвэрлэл эрхлэх	2	8	3	18	2	12
Өрхөөр болон хувиараа барилгын ажилд оролцох	3	1	5	1	4	1
Орлого олох зорилготой өрхийн худалдаа үйлчилгээ эрхлэх	11	7	9	9	10	8
Ажилтай холбоотой явах	45	35	26	19	35	28
Хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаа	111	243	85	271	97	256
Өрх гэрийн ажил, нүүдэл	77	185	62	224	69	203
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	30	57	16	44	23	51
Олон нийтийн болон сайн дурын ажил, тусламж	4	1	7	3	5	2
ҮТС-ийн бус үйл ажиллагаа	1 009	967	898	861	952	918
Боловсрол сургалтын үйл ажиллагаа	44	48	25	25	34	37
Хүмүүстэй харилцах болон шашны зан үйл	28	26	25	24	27	25
Чөлөөт цаг, спорт	181	139	137	115	158	128
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	756	754	711	697	733	728

Хүснэгт 10а. Ажлын нэг өдөрт судалгаанд хамрагдсан хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөө, хүйсээр, минутаар

Үйл ажиллагаа	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 440	1 440	1 440	1 440	1 440	1 440
Хөлстэй ажил эрхлэх үйл ажиллагаа	342	256	457	313	401	283
Байгууллагад ажил эрхлэх	241	185	79	84	157	139
